



**APU COMPANY**

Absolute. Pure. Unique.

**APU COMPANY**

Absolute. Pure. Unique.

Монгол улс, Улаанбаатар хот 17040,  
Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 48.  
Утас: 11-344837  
[www.apu.mn](http://www.apu.mn)

**2019**  
ЖИЛИЙН ТАЙЛАН

# АГУУЛГА

## 1 КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ЗАХИДАЛ	04
ҮНЭТ ЗҮЙЛС, БИДНИЙ БАРИМТЛАЛ	05
ТҮҮХЭН ТОВЧООН	07
КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	08
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ	09
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ	11
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ	15
ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	17
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО	19

## 2 БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ	21
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ	22
АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ	24
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ	25
ЗАХ ЗЭЭЛ, ӨНӨГГИЙН БАЙДАЛ	28
ЭКСПОРТ	35
ҮЙЛ АЖИЛЛАГАА	44
БИЗНЕС НЭГЖҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА	47
ЧАНАРЫН БОДЛОГО	53
ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД	55

## 3 БРЭНД ПОРТФОЛИО

АРХИ	57
ШАР АЙРАГ	63
УС, УНДАА, ШҮҮС	65
СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН	66
ИМПОРТЫН БРЭНД	70

## 4 ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ХҮНИЙ НӨӨЦ БА БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ	75
НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН	76


## 5 ТАЙЛАГНАЛ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	82
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	83
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	84
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	85
ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ	87
ТАЙЛБАР ТОЛЬ	88



1

## КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ



ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГЫН  
ЗАХИДАЛ

*АПУ компанийн хувьцаа эзэмшигч та бүхнийхээ амар мэндийг эрэн,  
Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс мэндчилж байна.*

Улиран одсон 2019 он бидний хувьд өмнөх жилүүдийн ололт амжилт, ахиц дэвшлээ бататган, олон улсын зах зээлд гарах дорвитой алхмуудыг хэрэгжүүлсэн жил байв. Нэгдмэл зорилгын төлөө хүчээ нэгтгэсэн АПУ групп компанийн чадварлаг хамт олны хүчин чармайлтаар бид 2019 онд тавьсан зорилтуудаа амжилттай биелүүлж, улсын төсөвт 300 гаруй тэрбум төгрөгийн татвар төллөө.

Өнгөрөгч онд экспортын стратегийн ач холбогдол бүхий ОХУ, БНХАУ-ын зах зээлд бүтээгдэхүүний борлуулалтаа өсгөн, ОХУ-ын зах зээлд тэргүүлэгч “Татспиртпром” компанитай түншлэлийн гэрээ байгуулсан нь онцлон тэмдэглэх амжилт байлаа.

Энэ нь АПУ компани дэлхийн стандартад нийцсэн үйлдвэрлэгч болсны нотолгоо бөгөөд Монгол Улсыг олон улсын шингэн хүнсний зах зээлд хүлээн зөвшөөрөгдсөн тоглогч болгон хөгжүүлэх чин хүсэл эрмэлзэл, хэтийн зорилгоо нэг алхмаар урагшлуулсан үйл явдал боллоо. Энэ амжилтыг бид цаашид улам бататган, хичээн ажиллах болно.

АПУ компанийн 2019 оны үйл ажиллагааны үр дүнг харгалзан Төлөөлөн удирдах зөвлөлөөс нэгж хувьцаанд 71 төгрөгийн ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргалаа. Ингэснээр өмнөх жилийн түүхэн дээд амжилтаа ахиулж, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудаас хамгийн өндөр дүнтэй ногдол ашиг хуваарилж байна.

Хөгжлийн түүхийг хамтран бүтээлцэж буй хүндэт хувьцаа эзэмшигчид, АПУ групп компанийн удирдлага, хамт олондоо чин сэтгэлийн талархал илэрхийлж, 2020 онд энх тунх, амар амгалан байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье!

Пүрэвийн **БАТСАЙХАН**

*Пүрэвийн Батсайхан*



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид нийгэмд баялаг бүтээх тулгуур хүч нь болж, өөрсдийн гаргасан амжилтаараа хүн, байгаль дэлхий, ирээдүйдээ хувь нэмрээ оруулахад оршино.

## ҮНЭТ ЗҮЙЛС

### • БИЗНЕС ЭРХЛЭЛТ:

Бид бүх шатанд багаар ажиллан хамтран туурвиж, хүмүүсээ зоригжуулан дуудаж, урамшуулан тэтгэн, тэргүүлэгч болохын төлөө эрмэлзэнэ.

### • ИЛ ТОД БАЙДАЛ:

Ил тод байдлыг эрхэмлэн, хийж буй ажилдаа бусдыг татан оруулж, урамшуулахын тулд зорилгоо бүрэн таниулна.

### • ӨВӨРМӨЦ БАЙДАЛ:

Бид тулгарсан сорилт бүрийг даван туулж, хамтран ажиллдаг түншүүд, нийгэмдээ дэмжлэг үзүүлэх ухаалаг замуудыг эрэхлхийлнэ.

### • ЧИН ШУДРАГА БАЙДАЛ:

Бид хийж байгаа зүйлээ үнэнч шударга, ёс суртахууны сахилга баттай гүйцэтгэж, Монгол улсын байгалийн баялгыг хойч үедээ өвлүүлэн үлдээж, дээд зэргийн стандартуудыг эдийн засаг, нийгэм, байгаль орчинд нэвтрүүлж, цаашид улам хөгжүүлэхийн төлөө ажиллана.



## БИДНИЙ БАРИМТЛАЛ

### ТӨГС.

#### ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- Бид хөгжлийг хөтөлж, нийгмийг манлайлан, зах зээл болон хамтрагчаа хүндэтгэж, үндсэн зорилгоо бүрэн таниулна.
- Компанийн санхүү, мэдээллийг ил тод, үйл ажиллагааг тогтвортой байлгана.
- Монголын тэргүүлэгч ажил олгогч байна.

### ТӨГӨЛДӨР.

#### СОЁЛ, БҮТЭЭГДЭХҮҮН

- Орчин цагийн зах зээлийг манлайлан тодорхойлж, хүнсний Монгол брэндийг бүтээн үйлдвэрлэгч байна.
- Дэлхийн түвшний бизнесийн байгууллагуудтай түншилж, хамтын ажиллагааг өрнүүлнэ.
- Монголын хэл, соёлын өвөрмөц өвийг хадгалан хамгаалж хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

### ТУНГАЛАГ

#### ЁС ЗҮЙ, ОРОН ЗАЙ

- Бид хүн, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмэр, үнэт зүйлээ дээдэлнэ.
- Компанийн хөгжил нь үйлдвэрлэлийн шинэ технологи дээр суурилна.
- Бизнесийн ил тод байдал, аюулгүйн нөхцөлийг хангаж ажиллана.

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

БРЭНД ПОРТФОЛИО

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ТАЙЛАГНАЛ

ТҮҮХЭН  
ТОВЧООН

1924

Монгол Ардын Намын Төв хорооны V хурал, Ардын засгийн газрын VII хурлаар "Архины онц эрхийг улсын санд авах тухай" дүрмийг баталжээ. Ийнхүү Улаанбаатар хотод 14 ажилтантай анхны архины үйлдвэр нээгджээ.

1927

Чех улсын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар анхны шар айраг үйлдвэрлэж эхэлсэн.

1958

Шар айрагны үйлдвэрт хөргөлт, даралтат хийн тоног төхөөрөмжийг шинээр суурилуулж, цагт 3000 шил шар айраг савлах хүчин чадалтай механикжсан урсгал шугамыг ашиглалтанд оруулан, техник технологийн дэвшилт хийв.

1961

Хийжүүлсэн амтат ундаа, Жанчивлангийн рашаан савлах цехийг шинээр байгуулжээ.

2003

Шар айрагны үйлдвэрийн хуучин барилга, шугам сүлжээ, техник, технологид иж бүрэн шинэчлэл хийж, жилд 20.0 сая литр шар айргийг шил болон ган торхонд савлах хүчин чадалтай үйлдвэрийг ашиглалтад оруулав. Монголын анхны шилтэй хар пиво "Хар Хорум" болон дээд зэрэглэлийн "Алтан Говь" шар айраг худалдаанд гарлаа. "Ерөөл" брэндийг зах зээлд гаргав.

2001

11 дүгээр сард Монгол Улсын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн хувьчлалын салхийг хагалж, компанийн төрийн мэдэлд байсан 51 хувийн хувьцааг дуудлага худалдаанд оруулснаар АПУ ХК хувийн өмчид бүрэн шилжив.

1992

Архи, пивоны комбинатыг АПУ ХК болгон зохион байгуулж, нийт хувьцааны 51 хувийг төрийн мэдэлд үлдээж, 49 хувийг Хөрөнгийн биржээр арилжаалсан.

2013

Шингэн хүнсний салбарт шинэ технологи, стандартыг нэвтрүүлсэн шар айрагны шинэ үйлдвэрийг, агуулахын стандартад дэвшилт гаргасан бүрэн автомат "АПУ Ложистик" төвийг тус тус бүтээн байгуулав. "Оргилуун" хийжүүлсэн усны брэндийг анх удаа Монголын зах зээлд нэвтрүүлсэн. Монголчуудын эртний танил "Борлио" шар айраг бүрэн шинэчлэгдэв.

2009

Хоногт 15.0 мянган литр тансаг зэрэглэлийн спирт үйлдвэрлэх хүчин чадалтай, Герман улсын техник, технологиор тоноглогдсон компьютерийн хяналт удирдлагатай, орчин үеийн Спиртийн шинэ үйлдвэр "Натур-Агро"-г улсын комисс хүлээн авч, ашиглалтад оруулжээ. Залуусын брэнд "Fusion" шар айраг болон хүүхэд залуусын уух дуртай "Фрутта" жимсний шүүсийг зах зээлд нэвтрүүлэв.

2006

АПУ ХК сүү, жимсний шүүсний үйлдвэрийг байгуулжээ. Мөн Тетра-Пак бүрэн автоматжсан шугамын хамт "Цэвэр Сүү" брэндийг хэрэглэгчдэд танилцуулсан.

2004

Ус, ундааны үйлдвэрийн хуучин барилга, шугам сүлжээ, техник, технологид иж бүрэн шинэчлэл хийж, жилд 4.5 – 5.0 сая литр бүтээгдэхүүнийг 0.33 л, 0.5 л, 1.5 л, 2 л-ийн хуанцар саванд савлах хүчин чадалтай үйлдвэрийг ашиглалтад оруулжээ. "АПУ Цэвэр ус"-ны брэндийг хэрэглэгчдийн гарт хүргэлээ.

2014

Сүү, сүүн бүтээгдэхүүнийг боловсруулах тоног төхөөрөмжөөр дэлхийд тэргүүлдэг Германы ГИА (GEA) компанитай хамтран сүүний шинэ үйлдвэрийг байгуулж ашиглалтад оруулав.

2017

Бизнесийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт тусгаарлалт: Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагааг АПУ ХК-аас тусгаарлаж, АПУ Дэйри ХХК-ийг үүсгэн байгуулсныг бүртгүүлсэн.

НЭГДЭЛ: Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 224 тоот "АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхийг зөвшөөрөх тухай" тогтоолоор АПУ ХК-ийн хувьцааг 321,304,553 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэхийг зөвшөөрч, хаалттай хүрээнд Хайнекен Азия Пасифик Пте. Лтд-д 266,091,981 ширхэг, Монголиан Бэвэриж Инвестментс ХХК-д 55,212,572 ширхэгийг тус тус эзэмшүүлэхийг зөвшөөрсөн.

2019

Дахин давтагдашгүй өв соёлоо сурталчлах зорилготой Монголын нэг өдөр, Millennium of Lххигу арга хэмжээнүүдийг ОХУ-ын Казань, Красносярск, Иркутск, Улан Удэ болон БНХАУ-ын Хөх хот, Ордос хотуудад зохион байгуулав. Үүний үр дүнд тухайн зах зээлд дээрх худалдааны цэгүүдийн тоог 938 хүргэлээ.

ОХУ-ын архи, архин бүтээгдэхүүний үйлдвэрлэлээрээ тэргүүлэгч Татспиртпром компанитай хамтын түншлэлийн гэрээ байгуулж, ОХУ-ын зах зээлд Чингис Хаан брэндийг онцгой эрхээр борлуулж эхэллээ.

## КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр: **АПУ**

Хэлбэр: **Нээлттэй хувьцаат компани**

МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал: **I**

Хувьцаа эзэмшигчдийн тоо: **6156**<sup>1</sup>

Компанийн эрх барих дээд удирдлага: **Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)**

ХЭХ-ын чөлөөт цагт компанийг удирдах этгээд: **Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)**


Гүйцэтгэх удирдлага: **Гүйцэтгэх захирал (Хувь хүн)**

## Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт

Шунхлай Групп ХХК нь өөрийн эзэмшлийн дараах компаниудыг өөртөө нэгтгэснээр АПУ ХК-ийн хувьцааны 56.03 хувийг эзэмших болсон.

- АПУ ХК-ийн хувьцааны 36.11 хувийг эзэмшдэг Туул Интернэшнл ХХК;
- АПУ ХК-ийн хувьцааны 14.03 хувийг эзэмшдэг Вит Аллианс Лимитед;
- АПУ ХК-ийн хувьцааны 5.19 хувийг эзэмшдэг Монголиан Бэвэриж Инвестмент ХХК.

## Хувьцаа эзэмшигчдийн бүтэц<sup>2</sup> :



<sup>1</sup> ҮЦТХТ ХХК-аас 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөр тасалбар болгон гаргасан Үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааны мэдээлэл

<sup>2</sup> Дээрхийн адил



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**ПҮРЭВИЙН БАТСАЙХАН**  
ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дарга

Шунхлай групп ХХК-ийн Ерөнхийлөгч  
Скайтел ХХК-ийн ТУЗ-ийн дарга, гишүүн  
2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга



**БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал  
2013 оноос хойш АПУ компанийн ТУЗ-ийн гишүүн



**СЕРГЕЙ ГРОМОВ**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Монгол Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга  
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



**КЕННЕТ ЧУ**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Хайнекен Азия Пасифик компанийн Гүйцэтгэх захирал  
2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



**ЯДАМДОРЖИЙН ДАМДИНСҮРЭН**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Хайнекен Азия Пасифик компанийн Төслийн удирдагч  
2019 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



**ТОМАС ХОЛЛАНД**  
ТУЗ-ийн ердийн гишүүн

Девелопмент Финанс Азия компанийн  
Хөрөнгө оруулалт хариуцсан захирал,  
Гүйцэтгэх захирал  
2019 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



### ӨЛЗИЙДЭЛГЭРИЙН БАТБАЯР ТУЗ-ийн хараат бус гишүүн

Баттур Трейвэл ХХК-ийн Ерөнхий захирал  
Улаанбуудайн эх газар ХХК-ийн Ерөнхий захирал  
Бату Дижитал ХХК-ийн ТУЗ-ийн дарга  
2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



### ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН ТУЗ-ийн хараат бус гишүүн

Нээлттэй хот ТББ-ын үүсгэн байгуулагч  
2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



### ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ ТУЗ-ийн хараат бус гишүүн

Монголын Банкны Холбооны Гүйцэтгэх захирал,  
Ерөнхий нарийн бичгийн дарга  
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



### ЧАДРААБАЛЫН АРИУНСАН ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

## ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн

### 01. АУДИТЫН ХОРОО:

- Ж. Үнэнбат (Хорооны дарга)
- Я. Дамдинсүрэн
- Ө. Батбаяр

### 02. НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО:


- П. Батсайхан (Хорооны дарга)
- Ө. Батбаяр
- Ё. Гэрэлчулуун

### 03. ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО:

- Ё. Гэрэлчулуун (Хорооны дарга)
- Ж. Үнэнбат
- Кеннет Чу

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

### Хувьцаа эзэмшигчдийн хурал (2016-2019)




АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурал 04 сарын 26-ны өдөр болж, нийт саналын эрхтэй хувьцааны 95.69 хувийг төлөөлсөн 383 хувьцаа эзэмшигч оролцож, дараах шийдвэрүүдийг гаргав.

Үүнд:

1. АПУ ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.
2. АПУ ХК-ийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу компани нийт энгийн хувьцааны 75 хувиас дээш хувийг эзэмшдэг өөрийн охин компани нэгтгэх, ийнхүү нэгтгэснээр компанийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй тохиолдолд тус шийдвэрийг гаргах бүрэн эрхийг ТУЗ-д олгох зохицуулалтыг тусгав.
3. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгов.
4. АПУ ХК-ийн ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүнийг 3 жилийн хугацаагаар сонгов.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ • 2019 оны ТУЗ-ийн хурлын статистик

### ТУЗ-ийн хурлын ирц ба гаргасан тогтоолын тоо



### ТУЗ-ийн хурал болон эчнээ санал хураалтад ТУЗ-ийн гишүүн тус бүрийн оролцсон байдал



\* Хувьцаа эзэмшигчдийн 2019.04.26-ны хурлаар шинэ ТУЗ сонгохоос өмнөх бүрэлдэхүүн

## ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

АПУ ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 676 тэрбум төгрөг байна. Жилийн арилжааны мэдээллийг графикаар үзүүлэв:

### Хувьцааны арилжаа



## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

### Ногдол ашгийн хуваарилалт (2016-2019)



АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02-р сарын 14-ний өдрийн хурлын 20/08 тоот тогтоолоор 2019 оны бизнесийн үйл ажиллагааны үр дүнг харгалзан нэгж хувьцаанд 71 (далан нэг) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн.

Ногдол ашгийн төлбөрийг компанийн нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-аар зуучлуулан, таваас дээш хувийг эзэмшигчдэд албан хүсэлтийн дагуу компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгож байна.



**ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ  
ХУРААНГУЙ**


## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ <sup>1</sup>

11% ↑



Цэвэр борлуулалтын орлого /тэрбум төгрөг/

-0.4% ↓




Борлуулалтын тоо хэмжээ /сая.литр/

44% ↑




Үйл ажиллагааны ашиг /тэрбум төгрөг/

58% ↑




Цэвэр ашиг /тэрбум төгрөг/

32% ↑



Бүтээгдэхүүний төрөл /SKU/

-2% ↓



Ажилчдын тоо

<sup>1</sup> 2018, 2019 онуудын үзүүлэлт нь Групп компанийн үзүүлэлт болно.



## ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

		Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2019	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2018	Өсөлт
БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ	мян.литр	132,641	133,225	-0.4%
<b>ОРЛОГО ҮР ДҮН</b>				
Цэвэр борлуулалтын орлого	сая.төг	472,634	425,908	11.0%
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	99,395	69,237	43.6%
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	76,113	48,243	57.8%
<b>БАЛАНС</b>				
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	192,641	183,914	4.7%
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	352,867	359,834	-1.9%
Нийт хөрөнгө	сая.төг	545,507	543,748	0.3%
Нийт өр төлбөр	сая.төг	64,225	89,353	-28.1%
Нийт эздийн өмч	сая.төг	481,283	454,395	5.9%
Нийт эздийн өмч ба өр төлбөр	сая.төг	545,507	543,748	0.3%
<b>МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>				
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	88,636	92,127	-3.8%
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(21,280)	(11,976)	77.7%
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(78,339)	(70,177)	11.6%
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(10,983)	9,975	-210.1%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	сая.төг	50,035	61,124	-18.1%
<b>ТАТВАР ТӨЛӨЛТ</b>				
Нийт татвар төлөлт	сая.төг	303,895	269,760	12.7%
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>				
Нийт хөрөнгө оруулалт	сая.төг	17,648	13,520	30.5%


## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

APU групп компани нь компанийн засаглалыг сайжруулах, олон улсын жишигт нийцүүлэн ажиллахаар шат дараатай олон ажлуудыг хийсэн.

Өнгөрсөн жилүүдэд эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлого, зарчмыг боловсронгуй болгох төгөлдөржүүлэх тал дээр анхаарч ажилласан бол 2019 онд бид эрсдэлийн удирдлагын салшгүй хэсэг болох "Залилангийн эсрэг удирдлага"-ыг групп компанийн хэмжээнд хэрэгжүүлж эхлээд байна. Мөн шингэн хүнсний салбарт Дэлхийд тэргүүлэгч, HEINEKEN компанийн "Бизнесийн ёс зүйн дүрэм"-г үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр Залилангийн эсрэг удирдлагыг цогцоор нь хэрэгжүүлэх суурь боломжийг бүрдүүлсэн юм. Үүний үр дүнд APU групп компани нь олон улсын стандартад нийцсэн эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, компанийн стратеги болон өдөр тутмын үйл ажиллагаанаас бий болж буй гол эрсдэл болон боломжуудыг удирдан ажиллаж байна.

2019 онд компанийн хэмжээнд Топ эрсдэлүүдийг тодорхойлон, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг боловсруулж, компанийн эрсдэлийн аппетитийн хүрээнд удирдан ажиллах боломжтой эрсдэлүүдийн магадлал/давтамж болон нөлөөллийг зохих түвшин хүртэл бууруулах, эрсдэлийг сулруулахад чиглэсэн компани ажлуудыг тогтмол зохион байгуулан ажиллалаа.

## ЭРСДЭЛИЙН ЗУРАГЛАЛ



## 2020 ОНД УЧИРЧ БОЛОХ ТОП ЭРСДЭЛҮҮД

ТОП ЭРСДЭЛҮҮД	ЮУ ТОХИОЛДОЖ БОЛОХ ВЭ?	ЭРСДЭЛИЙГ УДИРДАХЫН ТУЛД БИД ЮУ ХИЙЖ БАЙНА ВЭ?
Валютын ханшийн хэлбэлзэл	<p>* Дэлхийн худалдааны дайнтай холбоотой өмнөд хөршийн эдийн засгийн байдал, бизнесийн орчин тогтворгүй болж, ингэснээр Монгол улсын эдийн засгийн өсөлт удаахрах,                      * 2020 оны сонгуультай холбоотой зах зээл дээр төгрөгийн нийлүүлэлт нэмэгдэх                      * Монгол Улсын 2020 онд Төв банкны своп хэлцэл 12 тэр бум CNY, XXБ 500 сая USD, Энержи Ресурс ХХК 412 сая USD-н өрийн эргэн төлөлт хийгдэх ба ам доллар болон юанийн нийлүүлэлт буурч төгрөгийн эсрэг одооныхтой харьцуулахад өндөр хувиар чангарах төлөвтэй байгаа тул ТЭМ-н зардал мөн тэр хэмжээгээр өсөх магадлалтай.</p>	<p>Энэ төрлийн гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс үүдэлтэй эрсдэлийг удирдахад хүндрэлтэй ч ханшийн өсөлт, түүнээс үүсэх үр дагаврыг бууруулах зорилгоор эдийн засгийн нөхцөл байдал, валютын ханшийн таамаглах моделийг боловсронгуй болгох, валютын ханшийн хэлбэлзэл, трендийг тогтмол судалж шийдвэр гаргалтад ашиглах, мөн санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн хэрэглээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг эрмэлзэж ажилладаг.</p>
Үр тариа/улаан буудайн хомсдол	<p>* Байгаль орчны гэнэтийн өөрчлөлт, ган зудтай холбоотой 2019 оны байдлаар Дэлхий дахинаа үр тарианы экспортоор тэргүүлэгч орнууд хүртэл өөр улсаас үр тариа экспортлохоор төлөвлөж байгаа ба үр тарианы хомсдолд учраад байгаа. Харин Монгол улсын хувьд өмнөх онтой харьцуулахад 10 сарын байдлаар 12.1%-р буюу 17.1 мянган тонноор буурсан үзүүлэлттэй байгаа ба нийлүүлэлтийн хомсдол бий болох магадлал их байна.</p>	<p>Гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс үүдэлтэй эрсдэлийг удирдахад хүндрэлтэй ч нийлүүлэгч байгууллагуудтай нягт хамтран ажиллах, эрэлтийн оновчтой төлөвлөгөөнд тулгуурлан улаан буудайн нөөцийг оновчтой төвлөрүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна.</p>
Давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл	<p>* Хүн болон малын гоц халдварт өвчин эмгэг, хорио цээр зэргээс үүдэн орон нутагт борлуулалт тасалдах, борлуулалт буурах зэрэг томоохон үр дагаврыг дагуулж байдаг.                      * Байгаль орчны гэнэтийн өөрчлөлттэй холбоотой зам харгүй эвдрэх /төмөр зам эвдрэх/, холбоо харилцаа тасрах зэргээс үүдэн ТЭМ хугацаа хоцрох, бүтээгдэхүүний тээвэрлэлт тасалдах, тээврийн хорогдол нэмэгдэх улмаар үйлдвэрлэл болон борлуулалт тасалдах, зардал нэмэгдэхэд нөлөөлнө.</p>	<p>Давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл нь урьдчилан төлөвлөх боломжгүй гэнэтийн байдлаар үүсдэг бөгөөд тохиолдол бий болсон даруй үр дагавар нь илэрдэг тул компанийн зүгээс гэнэтийн болон хямралын үеийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, үйлдвэрийн төлөвлөлтийг алдагдал багатай түргэн өөрчлөх боломжоор хангах, аюулгүй ажиллагааг тогтмол ханган ажиллах зэргээр тухайн эрсдэлийн нөлөөллийг сулруулахыг зорьдог.</p>
Хэрэглэгчийн худалдан авалт буурах	<p>* Сүүлийн 10 жилийн статистик мэдээллээс харахад өрхийн зарлагад эзэлж буй хүнсний бүтээгдэхүүний хувь 5 орчим хувиар буурсан ба эрүүл мэнд, удаан эдэлгээтэй бараа, түрээс зэрэгт зарцуулах зардал эсрэгээрээ бага зэрэг нэмэгдсэн байгаа нь хэрэглэгчид өрхийн зардлаа танах, хямд үнэтэй бүтээгдэхүүн сонгох зэргээр бүтээгдэхүүний сонголтоо өөрчлөх нь борлуулалт буурахад нөлөөлөх магадлалтай юм.</p>	<p>АПУ компани нь бүтээгдэхүүнийг зохион бүтээхээс эхлээд эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн түгээлтэд гаргах хүртэлх бүхий л процесст чанар стандартыг өндөр түвшинд ханган ажилладаг ба хэрэглэгчдийнхээ хүсэл сонирхолд нийцсэн, дээд зэргийн чанартай, тунгалаг бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх түүгээрээ дамжуулан зохистой хэрэглээг нийгэмд таниулах, нийгмийн хариуцлагыг дээдлэн ажиллах замаар уг эрсдэлийг удирдан ажиллахыг эрмэлздэг.</p>
Одоогийн зах зээлээ бүс нутаг болон олон улсад тэлэх зорилгын биелэлт хангагдахгүй байх	<p>* ФАТФ-н олон улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулаагүй                      *ЭЗХАХБ-ын /OECD, Base erosion and profit shifting (BEPS)/ татвараас зайлсхийх асуудлыг шийдвэрлэх, олон улсын татварын дүрмийн уялдаа холбоог сайжруулах, татварын ил тод орчныг хангах чиглэлээр хамтран ажиллаагүй зэргээс үүдэн олон улсад Монгол улсын нэр хүнд буурах, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл сулрах, хамтын ажиллагаа удаахрах, компанийн бүтээгдэхүүний эрэлт буурах зэрэг сөрөг үр дагавартай.</p>	<p>Гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс үүдэлтэй эрсдэл тул компанийн зүгээс энэхүү эрсдэлийг удирдах, ямар нэг хариу арга хэмжээ авах нь ихээхэн хүндрэлтэй байдаг. Гэхдээ цаашид нэг эх үүсвэрээс шалтгаалсан олон төрлийн салбарласан эрсдэл нэмж үүсэхээс зайлсхийх зорилгоор компани гадаад харилцагч нартайгаа хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх тал дээр улам илүү анхааран ажиллах болно.</p>

\*Дээрх статистик мэдээллийг Монгол банк, УСТХ, ХХААХҮЯ болон FATF, OECD олон улсын байгууллагуудын мэдээлэл дээр тулгуурлан 2019.11 сарын байдлаар бэлтгэсэн болно.



2

## БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

"One day of Mongolia" арга хэмжээ  
2019 оны 12-р сарын 06-ны өдөр. ОХУ, Казань хот. Казань Палас зочид буудал



ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРЛЫН  
ЗАХИДАЛ

*Түүхэн замнал, Шинэ гарц, Сорилтын жил...*

АПУ компани төдийгүй Монгол Улсын хүнсний үйлдвэрлэлийн түүхт 95 жилийн ойг хамтдаа амжилт ололтоор дүүрэн үдэж, өнөөдөр та бүхэндээ түүхэн жилд хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээ тайлагнаж, энэхүү захидлыг илгээж буйдаа таатай байна.

Өнгөрөгч 2019 онд дэлхийн томоохон корпорацуудад менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг "Vain & Company" компаниас АПУ ХК болон М Би Си ХХК компаниудын нэгдлийг амжилттай хэрэгжсэн гэж дүгнэж, шинэ боломжуудаа нээсэн гайхалтай дурсамжуудаар дүүрэн жил байлаа. Бидний хувьд Монгол улсын эдийн засгийн таатай нөхцөл байдал (Эдийн засгийн өсөлт 2019 онд +6,7%)<sup>3</sup>, гадаад зах зээлийн эрэлтийн өсөлт, Хайнекен компанийн арга туршлага дээр үндэслэсэн нэгдсэн борлуулалтын систем, зах зээлд эзлэх тогтвортой байр суурь, ОХУ болон БНХАУ-д экспортын урт хугацааны бодлоготой уялдуулсан төсөл хөтөлбөр, зардлаа бууруулж, үйл ажиллагааны оновчтой менежментийг хэрэгжүүлсний үр дүн хэмээн харж байна.

Нэгдлийн үеэр удирдлагын багийн тухайн үед хувьцаа эзэмшигчдэдээ амлаж, ойрын зорилт болгон танилцуулж байсан экспортын ажлын хүрээнд уламжлалт

технологийн үнэ цэнийг орчин үеийн дизайн, брэндийн шийдлээр улам баяжуулж БНХАУ болон ОХУ-д өөрсдийн нэр хүнд, үнэ цэнийг бүтээж буйг дуулахад таатай байна. АПУ ХК-ийн нийт экспортын 55%-ийг БНХАУ эзлэх бөгөөд 2019 онд Өвөр Монголын зах зээлд чиглэсэн маркетингийн үйл ажиллагааны үр дүнд харилцагчдын тоог 50-аас 650-д хүргэж амжилтаа ахиулсан.

Экспортыг тэлэх зорилгоор уг оны аравдугаар сард ОХУ-ын Улаан-Үд, Эрхүү, Красноярск хотуудад "Millennium of Luxury" арга хэмжээг, арван хоёрдугаар сард Казань хотод "Монголын нэг өдөр" арга хэмжээг тус тус өндөр хэмжээнд, амжилттай зохион байгууллаа. Мөн уг ажлын хүрээнд Бүгд Найрамдах Татарстан Улсын Татспиртпром компанитай ОХУ-ын зах зээлд брэндүүдээ худалдаалах, үйлдвэрлэлийн боломжоо харилцан ашиглах талаарх тусгагдсан гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан явдал нь түүхэн жилийн оргил үйл явдал байв. Бид олон улсад зөвхөн брэнд бүтээгдэхүүнээ таниулахаас гадна эх орноо давхар сурталчлах, Монгол соёлыг түгээн дэлгэрүүлэхээр ажиллаж байна.

АПУ компанийн хувьд 344 нэр төрлийн 142.3 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд шинээр "Ауруг", "Боргио Вийг", "Сайн Актив" брэндүүдийг танилцуулж, "Чингис Грандхаан", "Ерөөл", "Фрутта зэрэг брэндүүдийг шинэчилж, "Сэнгүр Радлер Манго" шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн зах зээлд гарган ажиллалаа.

Тогтвортой ажлын байраар хангах бодлогын хүрээнд нийт ажилчдын тоо одоогийн байдлаар 2025 болсон байна. Хүний нөөцийн чиглэлийн хүрээнд ажилтнуудынхаа "карьер"-аа нэмэгдүүлэх боломжийг дэмжиж, HEINEKEN компанийн сургалт хөгжлийн цогц хөтөлбөрүүдийг үе шаттайгаар хэрэгжүүллээ.

Бид 2019 онд үйлдвэрлэл-үйл ажиллагааныхаа үр ашигт байдал, үнэ цэнийн гинжин хэлхээг нэмэгдүүлэх үүднээс үйлдвэрлэл болон тээвэрлэлтийн чиглэлд оновчлолын төсөл, процесс сайжруулалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр 1.3 тэрбум гаруй төгрөгийн хэмнэлт гарган ажиллалаа.

Түүнчлэн компанийн стратеги зорилтуудын нэг болох "Brewing Better World" буюу "Сайхан дэлхийг цогцлоо" стратегийн хүрээнд "Эргэлтийн болон эргэлтийн бус төрлийн лонхны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх" дэд төслийг хэрэгжүүлж үйлдвэрлэлд ашигласан лонхыг дахин ашигласнаар гадагшаа чиглэсэн гадаад валютын мөнгөн урсгалыг хааж, байгаль орчинд, ялангуяа хөдөө орон нутагт хаягдаж буй хог хаягдлыг бууруулах чиглэлээр тодорхой үр дүн гаргалаа.

Усны менежментийн болон эрчим хүчний хэрэглээг бууруулах төслүүдийг хэрэгжүүлж 11 мянган тонн усыг дахин ашиглаж, 603,8 мянга гаруй квт цахилгаан эрчим хүч хэмнэж ажилласан. Үйлдвэрлэлийн ханган нийлүүлэлтийг зөв төлөвлөж нийт 3.6 тэрбум төгрөгийн худалдан авалтын хэмнэлтийг хийж, чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015, ISO 14001:2005, SFSC 22000 стандартыг сунгасан, баталгаажуулсан зэрэг ололт амжилт дүүрэн жил байлаа.

Эдгээр тавьсан томоохон зорилтууддаа хамт олныхоо нөр их хөдөлмөр, хичээл зүтгэлээр амжилттай хүрч улсын төсөвт нийт 303.8 тэрбумын татвар төлсөн байна.

Энэхүү ашигтай ажиллахад нөлөөлсөн гол хүчин зүйл нь борлуулалтаас гадна компанийн хэмжээнд зардлаа бууруулж, үйл ажиллагааны оновчтой менежментийг хэрэгжүүлсэнтэй холбоотой гэдгийг энд дахин тэмдэглэе. Үүний дагуу хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилах тухай компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гарсан билээ.

2020 оны эхний улиралд дэлхий даяар тархсан шинэ төрлийн "Корона" вирус буюу "COVID-19" өвчлөлийн цар тахлын улмаас манай улсын эдийн засаг хямарч, дотоодын эрэлт багасч, ажилгүйдэл нэмэгдэж, өрхийн орлого буурах гэх мэт болзошгүй эрсдэлүүд бидэнд тулгарч байна. Энэ хүнд цаг үед АПУ ХК нь нийгмийн өмнө хүлээсэн үүргээ ухамсарлаж цар тахлын үед ажлын байраа тогтвортой хадгалж, улсад нэн шаардлагатай түүхий эдээр тасалдалгүй хангаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрт авч ажиллаж байна.

Энэ жилийн хувьд дэлхийн болон Монголын эдийн засгийн хүндрэл, экспорт болон импортын үйл ажиллагааны доголдол, худалдааны зохицуулалтаас хамаарсан томоохон сорилтод АПУ ХК нь бат зогсож, өөрсдийн хямралын үеийн бодлогыг олон улсын хамтран ажиллагч байгууллагуудын зөвлөмжтэй уялдуулан боловсруулж, даван гарах арга хэмжээнүүдийг яаралтай авч байна. 2020 оны хувьд халдварт өвчний эдийн засагт үзүүлэх нөлөөлөөс үл хамааран бид урт хугацааны зорилтуудаа биелүүлж, санхүүгийн сахилга батыг сахиж, улс орон, нийгмийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлнэ гэдгээ мэдэгдэе.

Нийт хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагч, хамт олон та бүхнийг нэгдмэл үзэл санаа, нэгэн зорилготойгоор эдгээр сорилтуудыг ХАМТДАА ИЛҮҮ ХҮЧТЭЙ -ээр даван гарч өөрсдийн амжилтыг бий болгож бусад хувийн хэвшлийнхэнд урам зориг, итгэл найдвар өгнө гэдэгт итгэлтэй байна.

Цэвээнжавын ЭРДЭНЭБИЛЭГ

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



**ЦЭВЭЭНЖАВЫН ЭРДЭНЭБИЛЭГ**  
Гүйцэтгэх захирал



**ХОУ ТЭЙК ПЭН**  
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа  
эрхэлсэн захирал



**ГОНЧИГИЙН ЭНХБИЛЭГ**  
Санхүү эрхэлсэн захирал



**ГАЛСУМЪЯАГИЙН БАЯРМАГНАЙ**  
Борлуулалт эрхэлсэн захирал



**АРИУНАА ДАНДАРОВА**  
Маркетинг эрхэлсэн захирал



**ЦООДОЛЫН ЭРДЭНЭЖАРГАЛ**  
Гадаад худалдаа эрхэлсэн захирал

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



**ШИПИЛОВЫН ДӨЛГӨӨН**  
Хүний нөөц, Захиргаа эрхэлсэн захирал



**САНЖИЙН ГАНЗОРИГ**  
АПУ Дэйри ХХК-ийн Гүйцэтгэх захирал



**БАТХҮРЭЛИЙН ЧИНТОГТОХ**  
Спирт Бал Бурам ХХК-ийн  
Үйл ажиллагаа эрхэлсэн захирал




**БАТСАЙХАНЫ ГАНТИГ**  
Байгууллагын Стратеги эрхэлсэн захирал



**ШАСНААБАДРААГИЙН БАТЖАРГАЛ**  
Байгууллагын Харилцаа эрхэлсэн захирал

## АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ



### • Охин компаниудын өөрчлөн зохион байгуулалт:

- 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр      Дедод ХХК татан буугдсан.
- 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдөр      Улаанбаатар Спирт ХХК татан буугдсан.
- 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдөр      Монголиан Бэвэрэйжс Компани Пте.Лтд татан буугдаж байгаатай холбогдуулан өөрийн эзэмшдэг Спирт бал бурам ХХК-ийн 97.19750%, СББ Трейд ХХК-ийн 100%, М Си Эс Азия Пасифик брьюэри ХХК-ийн 45%-ийн хувьцааг тус тус АПУ ХК-д шилжүүлсэн.
- 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр      М Си Эс Азия Пасифик Брьюэри ХХК-ийн оноосон нэр өөрчлөгдөж М Би Си Азия Пасифик ХХК болсон.
- 2019 оны 08 дугаар сарын 23-ны өдөр      Натур Агро ХХК-ийг АПУ ХК-д нэгтгэсэн.
- 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдөр      Монголиан Бэвэрэйжс Компани Пте.Лтд татан буугдсан.



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

2019 онд АПУ ХК нь үйл ажиллагааны стратегийг дараахь гурван чиглэлийн хүрээнд зохион байгуулж ажиллалаа.



01

**КОМПАНИ БА  
ХҮНИЙ НӨӨЦ**

- Компанийн бүтэц, засаглалын шинэтгэл болон хүний нөөцийн нэгдсэн бодлого, хуваарилалт

02

**ҮНЭ  
ЦЭНЭ**

- Үнэ цэнийг нэмэгдүүлэх боломж, санаачлагыг дэмжиж, шинэтгэлийн өгөөжийг нэмэгдүүлэх стратеги

03

**ҮЙЛ  
АЖИЛЛАГАА**

- Компаниудын үйл ажиллагааг шинэтгэн сайжруулах
- Мэдээллийн нэгдсэн систем

## 01 Компани ба хүний нөөц

### Компани:

- Бизнесийн үйл ажиллагааны өгөөж, бүтээмжийг бодит, өндөр түвшинд хүргэхээр төлөвлөж, бүтэц, зохион байгуулалтаа оновчилсон.
- Компанийн засаглалын циклийг өөрчилж, дунд хугацааны стратеги төлөвлөгөө, түүний хүрээнд жилийн төлөвлөгөөг тус тус боловсруулан ТУЗ-өөр батлуулж хэрэгжилтийг улирлаар хянаж байгаа нь төлөвлөгөөг бүхэлд нь бүрэн, бодитой хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн.

### Хүний нөөц:

- Бизнесийн үйл ажиллагааны өгөөж, бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд ажилтан тус бүрийн эрх, үүрэг, хариуцлагыг оновчтой тодорхойлж, хөдөлмөрийг зөв хуваарилсан.
- Олон улсын түвшинд ажиллах чадвар бүхий, мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, дадлагуулахад онцгойлон анхаарч сургалт, хөгжлийн нэгдсэн бодлого боловсруулж амжилттай хэрэгжүүлж байна.

## 02 Үнэ цэнэ

Компанийн үнэ цэнэ болон бизнесийн өгөөжийг нэмэгдүүлж, нэгдлийн дараах хамтын үр ашгийг сайжруулахын тулд дараах стратегиудыг баримтлан ажиллалаа.

### ЗОРИЛГО

Ашиг орлогоо нэмэгдүүлэх, инновацийг дэмжих

Бизнесийн бүтээмжийг сайжруулах

Нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийг эрхэмлэх

Хүний нөөцийн хөгжил, хамт олны нэгдмэл байдал

### СТРАТЕГИ

- Экспортод тулгуурлан зах зээлээ тэлэх
- Тоо хэмжээнээс илүү үнэ цэнэд төвлөрөх
- Инновацид суурилсан бизнес

- Үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагааны нийт бүтээмж, үр ашигт байдлыг нэмэгдүүлэх
- Зардал хэмнэх

- Аюулгүй байдлыг эрхэмлэх
- Хариуцлагатай хэрэглээг түгээх
- Байгаль, дэлхийд ээлтэй үйл ажиллагааг баримтлах

- Хүний нөөцийг чадавхижуулах, хөгжүүлэх
- Хойч үеэ манлайлах, залгамж халаа бэлтгэх

### ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Экспортод төвлөрч, үйл ажиллагааг өргөжүүлэн Гадаад худалдааны газрын бүтэц зохион байгуулалтыг оновчилж, экспортын стратегийг боловсруулж, баримтлан ажиллалаа.
- Брендийн багцыг оновчтой болгож, ашигтай брэндүүддээ төвлөрч, нөөцийг зөв зохистой хуваарилж ажиллалаа.
- Бизнесийн бүтцийн цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор Ус, ундааны бизнесийн нэгжийг Low and Non-Alcoholic шингэн хүнсний бизнес нэгж болгон өргөжүүлж, инновацид суурилан эрүүл мэндэд тустай, байгалийн гаралтай олон талын ач холбогдолтой шинэ бүтээгдэхүүнүүдийн судалгаа хөгжлийг боловсрууллаа.

- Үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагааны үр ашигт уялдааг хангах зорилгоор олон төслүүдийг санаачлан хэрэгжүүлж, үйл ажиллагааны стратегид суурилсан цогц бодлогыг баримтлан ажиллалаа.
- Бизнесийн өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд үйл ажиллагааны бүх түвшинд зардал хэмнэх F.O.R.C.E төсөл болон бусад санал санаачлагуудыг амжилттай хэрэгжүүллээ.

- Нийгмийн хариуцлагын хүрээнд нийгэмд зөв зохистой хэрэглээг түгээх, тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд үйл ажиллагааны бүхий л түвшинд аюулгүй ажиллагааг нэн тэргүүнд тавьж, цэвэр ус, эрчим хүчний хэрэглээгээ бууруулж, үйлдвэрээс гарах хог хаягдлыг дахин ашиглах төсөл хэрэгжүүлэн ажиллалаа.

- Хүний нөөцийн нэгдсэн бодлого боловсруулж, ажилчдын сургалт хөгжил, манлайлал, залгамж халаа бэлтгэх болон хувийн хөгжилд онцгой анхаарч, хамт олны нэгдмэл байдлыг нэмэгдүүлэх олон төрлийн арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.

## 03 Үйл ажиллагаа

Үйл ажиллагааг шинэтгэн сайжруулах

Компанийн бүтээмжийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахын тулд дараах хоёр чиглэлийг баримтлан ажиллалаа.

### Бүтэц, зохион байгуулалт:

- Гадаад худалдааны газрын бүтэц, зохион байгуулалтын оновчлол
- Борлуулалтын нэгдсэн бодлого, түүний хэрэгжилт

### Мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх

Нэгдэлд оролцогч компаниудыг мэдээллийн нэгдсэн систем болон дэд бүтцээр хангах, үйл ажиллагааны бүтээмжийг сайжруулах програм хангамжийг шинэчлэх зорилгоор ERP-г амжилттай нэвтрүүллээ.

### Үр ашигт байдал:

- Үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, үр ашигт байдлыг сайжруулах Total Management Productivity (TPM) төсөл, түүний хэрэгжилт
- Борлуулалтын үйл ажиллагааг нэгдсэн стандартад оруулах EOE & PICOS төсөл, түүний хэрэгжилт
- Үйлдвэрлэл болон борлуулалтын төлөвлөлтийг сайжруулах, үр ашигт байдлыг нэмэгдүүлэх S&OP төсөл, түүний хэрэгжилт





**ЗАХ ЗЭЭЛ,  
ӨНӨӨГИЙН  
БАЙДАЛ**

"One day of Mongolia" арга хэмжээ  
2019 оны 12-р сарын 06-ны өдөр. ОХУ, Казань хот. Казань Палас зочид буудал

## ЗАХ ЗЭЭЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ • Архины зах зээл

2019 онд Монгол Улсын архины зах зээл биет хэмжээгээр 27.7 сая литр хүрч, өмнөх онтой харьцуулахад 0.3 хувиар буурсан. Зах зээлийн 3% орчим нь хямд үнэтэй архины сегмент, 60%-ийг дундаж үнэтэй архины сегмент, 35%-с дээш хувийг үнэтэй болон импортын архины сегментүүд тус тус бүрдүүлж байна.

Зах зээлд иргэдийн худалдан авах чадвар сайжирснаар брэнд сонголт болон бусад категор руу шилжих үйл явц ажиглагдлаа.

АПУ ХК нь 2019 оны байдлаар нийт 16 брэндийн 74 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна.



## ЗАХ ЗЭЭЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ • Шар айргийн зах зээл

2019 онд Монгол Улсын шар айргийн зах зээл биет хэмжээгээр 5.1 хувиар буурч 90 сая гаруй литр хүрсэн. Зах зээл биет хэмжээгээр буурсан гол шалтгаан нь премиумизаци буюу худалдан авах чадвар сайжирсантай холбоотой хэрэглэгчийн хэрэглээний шилжилт байлаа.

2019 онд Монгол улсын шар айргийн зах зээлийн 5 хувийг импортын бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа ба энэ нь 2018 онтой харьцуулахад 3 хувиар буурсан үзүүлэлт юм.

Нийт шар айргийн зах зээлийн сегментүүд дээр онцгой өөрчлөлт гараагүй бөгөөд хэрэглэгчид өөрсдийн дуртай брэндүүдийг тогтмол сонгон хэрэглэж байна.



**ЗАХ ЗЭЭЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ • Ус, ундаа, шүүсний зах зээл**

2019 онд Монгол Улсын хийжүүлсэн ундааны зах зээл биет хэмжээгээр 180 орчим сая литр хүрч, өмнөх онтой харьцуулахад 4.4% өссөн бол савласан жимсний шүүсний зах зээл 6.2% өсч 68 сая литр, савласан цэвэр усны зах зээл 2.4% өсч 57 сая литр хүрсэн.

АПУ ХК нь 2019 оны байдлаар нийт 5 брэндийн, 18 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд үйлдвэрлэн нийлүүлж байна.



**ЗАХ ЗЭЭЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ • Сүү, Сүүн бүтээгдэхүүний зах зээл**

2019 онд Монгол Улсын сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл 3 хувиар өсч нийт зах зээлийн хэмжээ 60 гаруй сая литрт хүрсэн. Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл өсөлттэй байгаа нь Монголчуудын хэрэглээ уламжлалт хэрэглээнээс боловсруулж савласан хэрэглээ рүү шилжиж байгаатай холбоотой юм. Нийт зах зээлийн 60 гаруй хувийг сүүн бүтээгдэхүүн эзэлж байгаа бол үлдсэн 40 гаруй хувийг бусад сүүн бүтээгдэхүүнүүд эзэлж байгаа байна.





## ЗАХ ЗЭЭЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ • Дарсны зах зээл

2019 онд Монгол Улсын дарсны зах зээл 4 хувиар буурч нийт 2 сая гаруй литр болсон. Биет хэмжээгээр тус зах зээл нь бууралт үзүүлсэн боловч мөнгөн дүнгээр сүүлийн жил тасралтгүй өсч байгаа нь хэрэглэгчид илүүтэй чанартай дарсыг хэрэглэх эрмэлзэлтэй болсныг харуулж байна. Өнгөрсөн жил “АПУ” ХК нь дарсны зах зээлд амжилттай нэвтэрч дэлхийд алдартай Франц улсын “Maison Castel”, “Albert Bichot”, Испани улсын “Faustino”, Чили улсын “Concha y Toro” болон Аргентин улсын “La Chamiza” брэндүүдийг Монголын хэрэглэгчдэд хүргэж байна.



**ЗАХ ЗЭЭЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ • Импортын виски болон бусад зах зээл**

2019 онд Монгол Улсын Импортын вискины зах зээл биет хэмжээгээр 0.25 сая литр хүрч, өмнөх онтой харьцуулахад 25.0 хувиар өссөн. Манай улсын зах зээлд хямд үнэтэй вискиний брэндүүд зонхилон худалдаалагддаг.

Бусад импортын Коньяк/Брэнди, Жин, Ликёр, Текилла, Рам төрлүүд 2019 онд биет хэмжээгээр 0.2 сая литр хүрч, өмнөх оноос 30 орчим хувиар өссөн.

АПУ ХК нь 2019 оны байдлаар нийт 11 брэндийн импортын виски болон бусад спиртийн төрлүүдийг дотоодын зах зээлд нийлүүлж, энэ төрлийн зах зээлийн 7 орчим хувийг бүрдүүлж байна.





# ЭКСПОРТ

"Millennium of Luxury" арга хэмжээ  
2019 оны 10-р сарын 22-ны өдөр. ОХУ, Иркутск хотын Брэнштейны Галлерей, Бардо ресторан.

**ЭКСПОРТ • Зах зээл**



**ҮНДСЭН  
ЗАХ ЗЭЭЛ**



БНХАУ



ОХУ



Татваргүй  
бараа

**БУСАД ЗАХ  
ЗЭЭЛ**



БНСУ



ЯПОН




Европын  
Холбооны  
улсууд

**Стратегийн түншлэл**

Бид ОХУ болон БНХАУ-ыг экспортын гол зах зээл гэж харж байгаа бөгөөд үүнийхээ дагуу бүс нутагт нэр хүндтэй, борлуулалтын нэгдсэн сүлжээгээр үйл ажиллагаа явуулдаг TML, Shun Khe, Tatspirit Prom зэрэг ОУ-ын компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Мөн БНСУ, Япон болон Европын зарим орнуудад бүтээгдэхүүнүүдээ экспортолж байна.

ЭКСПОРТ • БНХАУ



АПУ ХК ийн экспортын нийт борлуулалтын 55%-ийг БНХАУ-ын зах зээл эзэлдэг буюу оны эцсийн байдлаар 11 хотын 650 гаруй худалдаа, үйлчилгээний цэгээр дамжуулан борлуулалт хийж байна. 2018 онтой харьцуулбал мөнгөн дүнгээр 78% борлуулалтын өсөлт гаргасан. 2019 онд БНХАУ-д зохион байгуулагдсан 2 удаагийн олон улсын үзэсгэлэнд амжилттай оролцож, түншлэл болон борлуулалтын цэгийг нэмэгдүүлсэн. Мөн “Чингис хаан” брэндийн архийг Өвөр Монголын зах зээлд амжилттай танилцуулсан билээ.

2020 онд Өвөр Монголоор зогсохгүй томоохон хотуудад нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Экспортлогдож буй брэндүүд

Архи

- 1. Chinggis Khan
- 2. Soyombo
- 3. Evok
- 4. Chinggis GrandKhaan
- 5. Eden

Шар айраг

- 1. Chinggis Khan
- 2. Алтан говь
- 3. Сэнгүр
- 4. Боргио
- 5. Нийслэл
- 6. Сэрүүн

БҮГД НАЙРАМДАХ  
ХЯТАД АРД УЛС

Хотууд

- |            |                   |              |            |
|------------|-------------------|--------------|------------|
| 1. Хөх хот | 4. Шилийн хот     | 7. Хулунбуйр | 10. Дабан  |
| 2. Эрээн   | 5. Баруун үзэмчин | 8. Баяннуур  | 11. Баутоу |
| 3. Ордос   | 6. Зүүн үзэмчин   | 9. Хишигтэн  |            |

ЭКСПОРТ • Арга хэмжээ • Хөх хот



ЭКСПОРТ • ОХУ



ОХУ-ын зах зээлд архины нийлүүлэлтэд төвлөрч ажилладаг бөгөөд өнөөгийн байдлаар 17 хотын 288 худалдаа, үйлчилгээний цэгээр дамжуулан борлуулалт хийсэн. Бид 2018 онтой харьцуулбал 28% борлуулалтын өсөлт гаргасан байна. Улан Удэ, Иркутск, Красноярск, Казань хотуудад харилцагчид уруу чиглэсэн “Millenium of Luxury”, “Монголын Нэг Өдөр” арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. Мөн ОХУ-ын тэргүүлэгч шингэн хүнсний үйлдвэрлэгч “Татспиртпром” ХК-тай хамтын ажиллагааны гэрээг 2019 оны 8-р сард байгуулсан. Түүнчлэн 12-р сард Казань хотод Чингис хаан брэндийг зах зээлд байршуулах “Монголын нэг өдөр” нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан.

Экспортлогдож буй брэндүүд

Архи

1. Chinggis Khan
2. Soyombo
3. Evok
4. Chinggis GrandKhaan
5. Болор
6. Алтан түрүү

Шар айраг

1. Chinggis Khan
2. Алтан говь
3. Сэнгүр
4. Боргио

Хотууд

- |                    |                |            |             |           |             |             |                 |             |
|--------------------|----------------|------------|-------------|-----------|-------------|-------------|-----------------|-------------|
| 1. Москва          | 3. Новосибирск | 5. Барнаул | 7. Иркутск  | 9. Чита   | 11. Киров   | 13. Братск  | 15. Усть-Илимск | 17. Казань  |
| 2. Санкт Петербург | 4. Красноярск  | 6. Абакан  | 8. Улан-Удэ | 10. Кызыл | 12. Ангарск | 14. Шелехов | 16. Норильск    | 18. Дербент |

ЭКСПОРТ • Арга хэмжээ • Улан-Удэ





ЭКСПОРТ • Арга хэмжээ • Иркутск



"Millennium of Luxury" арга хэмжээ  
2019 оны 10-р сарын 22-ны өдөр. ОХУ, Иркутск хотын Бронштейны Галлерей, ба Бардо ресторан.

**ЭКСПОРТ • Арга хэмжээ • Красноярск**



ЭКСПОРТ • Арга хэмжээ • Казань





# ҮЙЛ АЖИЛЛАГАА

"One day of Mongolia" арга хэмжээ  
2019 оны 12-р сарын 06-ны өдөр. ОХУ, Казань хот. Казань Палас зочид буудал

ҮЙЛ АЖИЛЛАГАА • Үнэ цэнийн гинжин хэлхээ

АПУ ОРЦ



САНХҮҮ

Хувь нийлүүлэгчдийн өмч, хөрөнгө, зээл тусламж, хөрөнгө оруулалт



БАЙГАЛИЙН НӨӨЦ

Ус, энерги, газар, байгалийн бүтээгдэхүүн



ХҮМҮҮН КАПИТАЛ

Ажиллагсад, эрүүл аюулгүй байдал, ёс зүйн зарчим



ҮЙЛДВЭРЛЭЛ

Барилга, үйлдвэрүүд, тоног төхөөрөмж



НИЙГЭМ

Нийгмийн холбоо хамаарал



ОЮУНЫ КАПИТАЛ

Брэнд, судалгаа хөгжүүлэлт, инноваци, үйл ажиллагаа, компанийн нэр хүнд

АПУ ГАРЦ

САНХҮҮ

472.6

тэрбум төгрөг

Цэвэр борлуулалтын орлого

303.8

тэрбум төгрөг

Татвар төлөлт

75.5

тэрбум төгрөг

Нийт зарласан ногдол ашиг

БАЙГАЛИЙН НӨӨЦ



4866

ТОНН

Усны хэмнэлт



603.8

МЯНГАН КВТ

Цахилгааны хэмнэлт

БҮТЭЭГДЭХҮҮН



344

Бүтээгдэхүүний нэр төрөл

НИЙГЭМ



ФС Улаанбаатар багтай хамтран ажиллалаа




Smiling Hearts арга хэмжээ өнгө нэмлээ



Зөв Зохистой Соёлтой Хэрэглээ!

## ХҮНИЙ НӨӨЦ





**БИЗНЕС  
НЭГЖҮҮДИЙН  
ТАНИЛЦУУЛГА**

"One day of Mongolia" арга хэмжээ  
2019 оны 12-р сарын 06-ны өдөр. ОХУ, Казань хот. Казань Палас зочид буудал

## БИЗНЕС НЭГЖҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА • Архи, спирт

**АПУ ХК АРХИНЫ ҮЙЛДВЭР**

Архины үйлдвэрийг 1972 онд ЗХУ-ийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар өргөтгөн шинэчилж, “Архи Пиво”-ны комбинат нэртэйгээр үйл ажиллагааг нь явуулж эхэлсэн. 2003 онд Архины үйлдвэрийн техник технологид иж бүрэн шинэчлэл хийж, Герман, Итали, Австри улсын тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулсан, жилд 200.000 гектолитр бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай, компьютер микро процессын хяналтын удирдлага бүхий үйлдвэрийг бий болгосон юм.

**СПИРТ БАЛ БУРАМ ХХК**

Спирт Бал Бурам ХХК нь ОХУ, Украин, Итали, Германы тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон. Архины үйлдвэртээ цагаан алтан болон мөнгөжүүлсэн хосолмол шүүлтүүрийг ашигладаг бүрэн автоматажсан үйлдвэр юм. 2009 онд хүнсний үйлдвэрлэлийн аюулгүй байдлын иж бүрэн хяналтын ажиллагаагаар ISO 22000 олон улсын стандартыг хангаж, 2010 онд Италийн бүрэн автомат шингэрүүлсэн нүүрсхүчлийн хий үйлдвэрлэх системийг нэвтрүүлснээр өдөрт 15 тонн спирт, цагт 6000 шил архи, 250 кг шингэрүүлсэн нүүрсхүчлийн хий үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр болсон юм.

**АПУ ХК СПИРТИЙН ҮЙЛДВЭР**

Спиртийн үйлдвэр нь Герман улсын “Шмитт” компанийн орчин үеийн дэвшилтэт технологи бүхий автомат тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон. Хоногт хүнсний этилийн “Альфа” буюу тансаг зэрэглэлийн 38000 литр спирт үйлдвэрлэх хүчин чадалтайгаас гадна эсгэлтийн явцад ялгарсан нүүрсхүчлийн хийг хуримтлуулан 99,9 хувь хүртэл цэвэршүүлэн боловсруулж “MCS Coca Cola”, “Pepsi” зэрэг томоохон компаниудад нийлүүлдэг. Мөн спиртийн шаарыг боловсруулан малын тэжээл байдлаар болон шингэн хэлбэрээр фермүүдэд нийлүүлж, спирт үйлдвэрлэлийн явцад гардаг техникийн спиртийг ХХАА-н яамны тусгай зөвшөөрлөөр гэрээт мал эмнэлэг, эмийн болон хэвлэлийн үйлдвэрүүдэд нийлүүлэн ажиллаж байна.



## БИЗНЕС НЭГЖҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА • Шар айраг

**АПУ ХК ШАР АЙРГИЙН ҮЙЛДВЭР**

1927 онд БНЧУ-ын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар анх шар айраг үйлдвэрлэснээр шар айргийн үйлдвэрийн суурь тавигдсан түүхтэй. 2002 он болон 2013 онуудад Германы Кронес компанийн байгаль орчинд ээлтэй үйлдвэрийн шаардлагыг бүрэн хангасан төхөөрөмжөөр бүрэн тоноглогдож, жилд 900.000 гектолитр литр шар айраг үйлдвэрлэх хүчин чадал бүхий Германы тэргүүлэх 5 үйлдвэртэй ижил төвшинд хүрсэн томоохон үйлдвэр болсон юм.

**М-БИ-СИ АЗИА ПАСИФИК ХХК**

Анх хэрэглэгчдээ дэлхийд таашаагдсан "Tiger" шар айргийг импортлон нийлүүлдэг байсан бол 2007 онд жилдээ 300.000 гектолитр бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий шар айргийн үйлдвэрийг ашиглалтанд оруулан, олон улсын хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн "Tiger" шар айргийн брэндийг эх орондоо үйлдвэрлэж эхэлсэн. Тус үйлдвэр нь Германы Кронес, Хупман фирмийн бүрэн автоматчилагдсан шугамтай цагт 15000 ширхэг лаазтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтайгаас гадна үйл ажиллагаандаа ISO 22000 - Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо; ISO 9001 - Чанарын удирдлагын тогтолцоог бүрэн нэвтрүүлсэн. Чанартай, аюулгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тогтолцоо бүхий анхны үйлдвэрлэгч болсон түүхэн үйл явдлын эзэн болсон юм.

**БИЗНЕС НЭГЖҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА** • Ус, ундаа, шүүс**АПУ ХК УС, УНДААНЫ ҮЙЛДВЭР**

Ус ундааны үйлдвэр нь 2002 онд АПУ компани хувьчлагдан хувийн өмчит компани болсноор бие даасан үйлдвэр болсон юм. Үйлдвэрийг шинэчлэх ажлыг 2004 оноос эхлүүлэн Герман улсын KRONES, Грунбек компаниудтай хамтран савлах шугамын хүчин чадлыг 4 дахин нэмэгдүүлж, усыг 4 давхар шүүлтүүрээр шүүн цэвэршүүлэх системийг нэвтрүүлсэн. Тус үйлдвэр нь ус, ундаа, шүүс, шар айргийн 13 нэр төрлийн бүтээгдэхүүнийг 25 төрлийн савлагаагаар үйлдвэрлэж хэрэглэгч олондоо хүргэн ажиллаж байна.

## БИЗНЕС НЭГЖҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА • Сүү, Сүүн бүтээгдэхүүн

**АПУ ДЭЙРИ ХХК**

АПУ Дэйри ХХК нь 2017 онд бие даасан аж ахуй нэгж болон өргөжиж, өдөрт 150 тонн бүтээгдэхүүн боловсруулах, жилд 45 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтайгаар Сайн, Маамуу, Дээж, Цэвэр сүү брэндийн 32 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Тус үйлдвэр нь Герман улсын GEA брэндийн тоног төхөөрөмж бүхий боловсруулах хэсэг болон Швед улсын Tetra Pak, Ecolap савлах шугам, Япон улсын Elorak, ENEDG буюу Европын холбооны сүү боловсруулах үйлдвэрийн стандартын дагуу баригдсан бүрэн автомат тоног төхөөрөмж бүхий хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт үйлдвэр юм. Монголдоо анх удаа түүхий сүүн дэх антибиотик, соматик эсийн хэмжээг өөрийн лабораторидоо хэмждэг, Англи, Германы шинжилгээний багаж хэрэгслээр бүрэн тоноглогдсон итгэмжлэгдсэн лабораторитой үйлдвэр юм. Мөн 2018 онд Монгол Улсад анхны кластер ферм байгуулсан бөгөөд Улаанбаатар хотоос 95 км зайд тус бүр 40 саалийн үнээтэй өрхүүд нэгдэн, нийт 400 үнээтэй 10 ферм бүхий Монголын анхны сүүний кластер ферм үйл ажиллагаагаа эхлүүлсэн болно. Үүний үр дүнд фермээс бэлтгэгдсэн сүүг тогтвортой үнээр жилийн дөрвөн улирал худалдан авч боловсруулан хэрэглэгчдэд хүргэх боломжтой болсон юм.

## БИЗНЕС НЭГЖҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА • ЛОЖИСТИК ТӨВ

**АПУ ЛОЖИСТИК ТӨВ**

Агуулахын багтаамж: Байгууламжийн өндөр нь 34м, урт нь 116м, өргөн нь 36м, эзлэхүүн нь 96,000 куб метр юм. АПУ ХК нь 2013 онд ХБНГУ-ын Krones компанитай хамтран дэлхийн стандартад нийцсэн, хүчин чадлын хувьд Ази тивийн ТОП 5 агуулахын нэг, Монголдоо хамгийн томд тооцогдох бүрэн хэмжээний “АПУ Ложистик” автомат агуулахаа ашиглалтанд оруулсан. Уг автомат агуулах нь Цагт 58 подоон хүлээн авах, цагт 63 подоон бүтээгдэхүүн гаргах хүчин чадалтайгаас гадна үйлдвэрээс бэлэн болсон бүтээгдэхүүнийг үйлдвэрийн дамжлагаас нь шууд татан төвлөрүүлж, тогтмол хэмд хадгалж, захиалгын дагуу буцаагаад түргэн шуурхай түгээдэг бүрэн автомат үйлдвэрлэл юм. Уг автомат агуулах нь эрс тэс уур амьсгалтай, манай орны нөхцөлд хадгалалт, хамгаалалтын горимыг ийнхүү чанд мөрдөн, хэрэглэгчдийн гарт стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнийг хүргэн ажиллаж байна.

## ЧАНАРЫН БОДЛОГО • Чанарын удирдлага



Чанар гэдэг нь зөвхөн бүтээгдэхүүний чанарын тухай ойлголт биш юм. Бүтээгдэхүүний чанараас гадна процессийн чанарыг хянаж баталгаажуулснаар бидний хийж буй бүхий л үйлдэлд чанар шингэсэн байдаг.

АПУ компани ISO9001 Чанарын удирдлагын тогтолцоо, ISO14001 Байгаль орчны удирдлагын тогтолцоо болон FSSC22000 Хүнсний аюулгүй байдлын тогтолцооны стандартуудыг хамтад нь нэвтрүүлсэн Монголын анхны компани юм.

Чанарын алба нь чанарын хяналт, чанарын баталгаажуулалт, чанарын удирдлагын тогтолцоо гэсэн үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Бүтээгдэхүүнийг зохион бүтээхээс эхлээд түүхий эд материалын чанарыг шалган, хүлээн авах, хадгалах, эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн, түгээлтэд гаргах хүртлэх бүхий л процессд сорилт, шинжилгээ, туршилт, чанарын хяналт, баталгаажуулалтын үйл ажиллагааг Олон улсын стандарт, журам заавартай нийцүүлэн, байнгын мониторингийн хяналт тавих цогц үйл ажиллагаа юм.

АПУ компанийн стратеги зорилгын нэг болох “Үлэмжийн дээд чанарыг бий болгох” зорилгын хүрээнд 2019 онд бид дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Процессын чанарыг сайжруулахын тулд “Quality Improvement Idea” аян
- Алба нэгжүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулан, мэдлэг чадвараа бусаддаа түгээхийн тулд “Audit Eye” аян
- Баримт бичгийн хяналт, тархалтыг сайжруулахын тулд “Баримт бичгийн соёлыг бий болгох нь” хөтөлбөр

Бид үйл ажиллагаагаа Олон улсын стандарт, дүрэм, журманд нийцүүлэн, АПУ компанийн ажилтан бүрийн оролцоотойгоор чанарын соёлыг бий болгож, хэрэглэгчиддээ үлэмжийн дээд чанарыг бүтээгдэхүүн бүртээ амалж байна. Бидний амжилтын үндэс бол Чанар болон Монгол хүний олон жилийн туршлага, ур ухаан шингэсэн технологи юм.

## ЧАНАРЫН БОДЛОГО • Итгэмжлэгдсэн лаборатори

АПУ групп компанийн хэмжээнд бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах болон судалгаа шинжилгээ хийдэг төв лаборатори 5, үйлдвэрлэлийн шугамын дэргэдэх бүтээгдэхүүний хяналтын дагуул лаборатори 9, нийт 14 лаборатори 24 цагийн үйл ажиллагаатай ажиллаж байна. Төв лабораторууд нь бүгд олон улсын стандартын байгууллагаас баталсан стандарт, дүрэм, журам, шинжилгээний арга аргачлал, норматив техникийн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажилладаг.

Эдгээр лабораториуд нь олон улсын сорилтын лабораториудын чадавхид тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025 : 2018 стандартын шаардлагыг тогтмол ханган ажилласаар ирсэн ба Олон улсад лабораторийн тоног төхөөрөмжөөр тэргүүлэгч АНУ, Герман, Австри, Солонгос, ОХУ-ын орчин үеийн шилдэг, нано технологи бүхий өндөр мэдрэмжит тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон. Манай лабораториуд нь үйлдвэрлэлдээ дотоод хяналтыг тавихаас гадна үйл ажиллагааныхаа чиглэлээр Heineken-ий олон улсын лабораториудын сорилт, шалгалтын байгууллага, Англи улсын Фипас-ын олон улсын лабораторийн ур чадварын уралдаан зэрэгт өндөр амжилттай оролцсон. Мөн Герман улсын VLB, Weihenstephan институт, ОХУ-ын Interlab, ФГБНУ ВНИИПБТ институт, Монгол улсын судалгаа шинжилгээний хүрээлэнгүүд, их дээд сургуулиудтай судалгаа шинжилгээний чиглэлээр хамтран ажилладаг судалгааны томоохон бааз юм.

АПУ Групп компанийн дотоод хяналтын лаборатори нь дараах бодлогыг баримтална.

- Лабораторийн чанарын удирдлагын тогтолцоо болон сорилт шинжилгээний нэгдмэл байдлыг ISO/IEC 17025 стандартын шаардлагад нийцүүлж, байнгын сайжруулалтаар хангана.
- Ажилтан ажиллагсдын хөгжил, техник технологид чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг ханган ажиллана.
- Болзошгүй санхүүгийн болон бусад хүчин зүйлээс хараат бус байдлаар үйл ажиллагаагаа тасралтгүй явуулна.



## ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД





3

## БРЭНД ПОРТФОЛИО

"Millennium of Luxury" арга хэмжээ  
2019 оны 10-р сарын 22-ны өдөр. ОХУ, Иркутск хотын Бронштейны Галлерей, Бардо ресторан.



## БРЭНД ПОРТФОЛИО • Архи

### Чингис хаан

Товч танилцуулга:

Анхны ультра супер премиум (дээдийн дээд) зэрэглэлийн энэ цэвэр цагаан архийг зургаан давхар (нүүрс, кварц, очир алмааз, сувд, мөнгө) шүүлтүүрээр гаргаж авсан альфа зэрэглэлийн цэвэр спирт ашиглан гүний цэнгэг усаар үйлдвэрлэсэн. "Чингис Хаан" брэндэд лаванда цэцэг, аньсны үр, буудайн үрний үнэр, амтыг шингээж өгсөн.

Савлагаа: 1л 0.75л  
Спиртийн агууламж: 40,0%



### Соёмбо

Товч танилцуулга:

Монгол төрийн бэлгэдэл алтан Соёмбо үсгээр нэрлэгдсэн супер премиум (дээдийн дээд) зэрэглэлийн энэ тансаг архийг үйлдвэрлэхдээ тусгайлан сонгосон шилмэл улаан буудайн альфа зэрэглэлийн спирт, гүний цэнгэг усыг ашиглаж үйлдвэрлэсэн. "Соёмбо" брэнд нь уламжлалт шүүлтийн технологийг орчин үеийн дэвшилтэт шүүлтүүртэй хослуулан, зургаан төрлийн нэмэлт өвөрмөц амт, үнэрийг шингээж гаргасан тансаг зөөлөн амттай архи юм.

Савлагаа: 1л 0.75л 0.5л  
Спиртийн агууламж: 39.5%



БРЭНД ПОРТФОЛИО • Архи



**Evok**

**Товч танилцуулга:**  
Бид дэлхийн нэр хүндтэй Heineken-ний олон улсын багтай хамтран амт чанар, өнгө үзэмжийн хувьд давтагдашгүй Дэлхийд өрсөлдөхүйц тансаг зэрэглэлийн брэндийг Монголдоо үйлдвэрлэхээр 2 жил гаруй хугацаанд шаргуу хөдөлмөрлөсний эцэст 2014 оны 8 сарын 4-нд өөрийн гэсэн хэв маяг, загвар дизайн, амт чанараараа давтагдашгүй EVOK брэнд анхлан Монголын зах зээлд мэндэлсэн. EVOK брэнд АНУ, Сан Франциско хотноо зохион байгуулагдсан олон улсын архин бүтээгдэхүүний чансааг тодорхойлогч, хамгийн нэр хүндтэй тэмцээн болох "WORLD SPIRIT COMPETITION 2015" уралдаанаас шалгарч дээдийн дээд шагнал болох ХОС АЛТАН МЕДАЛИЙГ хүртсэн.

**Савалгаа: 1.75л, 0.75л  
Спиртийн агууламж: 39.0%**



**Velvet**

**Товч танилцуулга:**  
"VELVET" брэнд нь залуусын цагийг зугаатай, хөгжилтэй өнгөрүүлэх тансаг үдшийн хэв маягийн илэрхийлэл бөгөөд энэхүү бүтээгдэхүүнийг шинийг санаачлах хүсэл эрмэлзэлтэй, өөртөө итгэлтэй эрч хүчээр дүүрэн бүсгүйчүүд болон залуус та бүхэндээ зориулан 2016 онд АПУ компани, шинэ үеийн төлөөлөл болсон залуу үеийнхэндээ хүргэж байна. "Эрх чөлөөгөө тунхагла!"

**Савалгаа: 0.7л 1л  
Спиртийн агууламж: 38.0%**



**Eden**

**Товч танилцуулга:**  
Өөрийн гэсэн мэдрэмжээр ертөнцийг хардаг, урлаг уран сайхныг таашааж үздэг, зорилго мөрөөдөлдөө үнэнч хэн бүхэнд зориулан АПУ компани "Мэдрэмж хөглөх амт" буюу "EDEN"(ЭДЕН) брэндийг 2016 онд зах зээлд нэвтрүүлээ. "Мэдрэмж хөглөх Eden"

**Савалгаа: 0.7л 1л  
Спиртийн агууламж: 36.0%**



**Болор**

**Товч танилцуулга:**  
Монгол хүн сансарт ниссэн түүхэн үйл явдлыг тохиолдуулан үйлдвэрлэсэн энэ архийг 1981 онд зах зээлд анх гаргаж байсан бөгөөд 2008 онд шинэчлэхдээ уламжлалт амт чанарыг шингээж үйлдвэрлэсэн. Шилмэл сортын улаан буудайн тансаг зэрэглэлийн спиртээр үйлдвэрлэдэг энэ архийг 2011 оноос эхлэн анхилуун жүржний ба цангис жимсний амт шингээж шинэ хоёр төрлийг зах зээлд гаргах болсон.

**Савалгаа: 1л 0.75л 0.5  
Спиртийн агууламж: 39.0%**



## АУРУГ



### Ауруг Голд

**Товч танилцуулга:**  
Эртний эрдэнэ лугаа төгөлдөр урлан, онги тамгатай зоос шигтгэн, алтан өнгөөр хөвөөлөн чимж, дээдийн дээд охь спиртийг цэвэр тунгалаг усаар найруулан, 9 эрдэнийн шүүлтүүрээр тунгаан шүүж, уламжлал шинэчлэлийг хослуулан бүтээсэн дээдийн дээд төгөлдөр сархад Ауруг.

**Савалгаа: 0.7л 0.5л**  
**Спиртийн агууламж: 38%**



### Ауруг Силвер

**Товч танилцуулга:**  
Их Ордоо бэлгэдсэний учир дээдийн дээдийг дээжлэн урлав. Ариг тунгалаг усаар зохируулан зөөлрүүлж, мөнгөн эрдэнийн гурван давхар шүүлтүүрээр шүүн ихэд эрхэмлэн Ауруг хүндэтгэлийн сархдаа бүтээлээ.

**Савалгаа: 0.7л 0.5л**  
**Спиртийн агууламж: 36%**

### 9 ЭРДЭНИЙН ШҮҮЛТҮҮР



Алт



Зэс



Мөнгө



Тана




Ган



Номин



Шүр



Оюу



Сувд



## CHINGGIS GRANDKHAAN

### Товч танилцуулга:

45 жилийн арвин туршлагатай "Спирт бал бурам" ХХК-ийн мэргэжилтнүүдийн бүтээсэн хамгийн анхны премиум зэрэглэлийн брэнд Чингис ГРАНДХААН 2002 онд зах зээлд танилцуулагдаж байсан түүхтэй. Зах зээлд гарсан цагаасаа хойш олон улсын бүхий л нэр хүндтэй тэмцээн уралдаанд амжилттай оролцож хамгийн олон шагналын эзэн болж Монголын нэрийг дэлхийд таниулсан экспортын шилдэг брэнд болж чадсан юм.



### Чингис Грандхаан Цагаан

#### Товч танилцуулга:

Монголд анх удаа "Milk Filter" буюу сүүн шүүлтүүрийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, нэмэлт хүнсний бодис ашиглахгүйгээр, цэвэр сүүгээр архин бүтээгдэхүүний найрлага дахь химийн элементийг шүүж, хоруу чанарыг бууруулдаг тусгай технологийг Цагаан Чингис брэнддээ нэвтрүүлснээр, илүү таатай зөөлөн амтыг, өвөрмөц ёс заншил, бахархах түүхтэй Монгол түмнийхээ хэрэгцээнд онцгойлон зориулан бүтээсэн тансаг зэрэглэлийн бүтээгдэхүүн юм.

Савалгаа: 0.7л 0.5л  
Спиртийн агууламж: 39%



### Чингис Грандхаан Оригинал

#### Товч танилцуулга:

40 жилийн арвин туршлагатай "Спирт бал бурам" ХХК-ийн мэргэжилтнүүдийн бүтээсэн хамгийн анхны тансаг зэрэглэлийн брэнд Чингис 2002 онд зах зээлд танилцуулагдаж байсан түүхтэй. Зах зээлд гарсан цагаасаа хойш олон улсын бүхий л нэр хүндтэй тэмцээн уралдаанд амжилттай оролцож хамгийн олон шагналын эзэн болж Монголын нэрийг дэлхийд таниулсан экспортын шилдэг брэнд болж чадсан юм.

Савалгаа: 0.7л 0.5л  
Спиртийн агууламж: 39%

## БРЭНД ПОРТФОЛИО • Архи

### ARKHI

Товч танилцуулга:  
Шилмэл сортын улаан буудайн тансаг зэрэглэлийн спиртээр 1976 онд экспортод гаргах зорилгоор анх үйлдвэрлэж байсан цэвэр "ARKHI" брэндийг 2011 онд дахин шинэчлэн худалдаанд гаргасан. Уламжлалт шүүлтийн технологийг орчин үеийн дэвшилтэт шүүлт болох нүүрсэн, элсэн, мембранан болон дөрвөн давхар мөнгөжүүлсэн шүүлтүүртэй хослуулан гаргаж авсан зөөлөн амттай "ARKHI" нь ямар нэгэн нэмэлт орц агуулаагүй цэвэр цагаан архи юм.  
Уг брэнд 2016 онд дэлхийн зах зээлд нэвтэрсэний 40 жилийн ой тохиосон ба уг үйл явдалд зориулан шинээр төрөлжүүлэн ARKHI EXPORT 40 гэх энэхүү премиум зэрэглэлийн дахин давтагдашгүй тансаг идээний дээжийг нийт хэрэглэгчиддээ өргөн барьсан болно.



Савалгаа: 0.75л 0.5л 0.35л 0.2л 0.1л Спиртийн агууламж: 38%

### Алтантүрүү

Товч танилцуулга:  
Амт, чанараараа дэлхийд танигдсан Алтантүрүү брэнд нь шилмэл сортын улаан буудайн тансаг зэрэглэлийн спирт болон цэвэр усны найрлагатай юм.



Савалгаа: 0.75л 0.5л Спиртийн агууламж: 38.5%

### Тайга

Товч танилцуулга:  
Тайга брэнд нь Монгол нутгийн хөрсөнд ургасан эмийн ургамал, жимсгэнийн ханд агуулсан онцгой агуулсан байгалийн гаралтай цагаан архиийг зах зээл дээр 2016 онд хэрэглэгч олондоо бэлэг болгон хүргэж байна. "Mongolian Natural Vodka"



Савалгаа: Өвөл Зун Хавар Намар 0.75л 0.5л Спиртийн агууламж: 39% 35% 38% 38%

### Шинэ Улаанбаатар

Товч танилцуулга:  
Анх 1963 онд худалдаанд гарч байсан "Улаанбаатар" архийг нэгдүгээр зэргийн спирт, цэвэр усны найрлагатайгаар кварц чулуун шүүлтүүр ашиглан үхрийн нүдний нэмэлттэй, өвөрмөц амт шингээж 2012, 2017 онуудад шинэчлэгдэн хэрэглэгчийн гар дээр хүрч байсан бөгөөд 2018 онд брэндийг эрс шинэчилж хэрэглэлийн таашаалд нийцэхүйц хүчилтөрөгчөөр баяжуулан худалдаанд гаргасан



Савалгаа: 0.75л, 0.5л Спиртийн агууламж: 38%

### Ерөөл

Товч танилцуулга:  
Өлзийт ерөөл өнөд оршихыг бэлгэдэн эх орныхоо хөрсөнд ургасан улаанбуудайг исгэн, дээд зэрэглэлийн шимийг нь мөнгөн шүүлтүүрээр ариутган монгол түмэн, айл бүрт хишиг буян дэлгэрч байхыг бэлгэдэн Хөх хадагтай Ерөөлөө брэндийг мөнгөжүүлсэн шүүлтүүрээр тунгаан 2003 онд худалдаанд гарсан юм. Люкс зэрэглэлийн спирт, зөөлрүүлсэн усаар уламжлалт шүүлтийн технологийг орчин үеийн дэвшилтэт шүүлтүүртэй хослуулан үйлдвэрлэдэг.



Савалгаа: 0.75л 0.5л 0.35л 0.1л 0.05л Спиртийн агууламж: 38.0%

### Хараа

Товч танилцуулга:  
Хараа брэнд анх 1993 онд үүссэн анхны архины брэнд бөгөөд үүссэн цагаасаа хойш өнгө төрхөө олон удаа шинэчилж, одоо Цэвэр Хараа, Зөөлөн Хараа гэсэн хоёр төрлөөр гарч байна. Цэвэр Хараа брэнд нь уламжлалт болон орчин үеийн технологийг хослуулсан "Мөнгөжүүлсэн шүүлт"-ээр бүрэн шүүж чадсан дэвшилтэт бүтээгдэхүүн юм. Зөөлөн Хараа брэнд нь илүү зөөлөн амтыг таашаадаг хэрэглэгчиддээ зориулан Алтжуулсан шүүлтийг ашиглан гаргасан онцгой сайн бүтээгдэхүүн болж чадсан.



Савалгаа: 0.75л 0.5л 0.35л 0.2л 0.1л Спиртийн агууламж: 38%



## БОРГИО

ХӨЛ БӨМБӨГИЙН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГ

PLAYTIME 2019

FIFA 2022 болон AFC 2023 тэмцээний урьдчилсан шатны "F" хэсгийн тоглолтуудад Боргио хамт байлаа.

Жил бүр зохион байгуулагддаг амьд хөгжмийн PLAY-TIME 2019 наадамтай хамтран ажиллав.



Монгол улсын шар айрагны түүхийн хуудсыг эхлүүлсэн Боргио брэнд нь үндэсний шар айргийн төгс илэрхийлэл юм. Үндэсний бахархалт брэнд "Боргио" шар айраг нь 1927 оноос эхлэн Чех мэргэжилтнүүдийн тусламжтайгаар үйлдвэрлэж эхэлсэн. Энэхүү эхлэл нь одоогийн Боргио брэндийн үндэс болсон бөгөөд 1940д оноос хэрэглэгчдэд Боргио нэрээр хүрч эхэлсэн.

### Боргио

Товч танилцуулга:  
Экспортод гаргаж байсан анхны шар айраг "Боргио"-г Германы дэвшилтэт технологиор шинэчлэж, 5.5%-ийн спиртийн агууламжтай гашуунлагийн хэмжээг 21-ээс 15 болгон бууруулж, савалгааны өргөн сонголттой үйлдвэрлэж байна.



Савалгаа: 0.45л, 0.5л, 2.5л  
Спиртийн агууламж: 5.5%

### Боргио вийт

Товч танилцуулга:  
Үндэсний ууган брэнд Боргио брэндийн хэгэн шинэ төрөл БОРГИО WHEAT буюу улаан буудайн шар айраг зах зээлд гарлаа. Боргио энгийн лагер шар айргийн орцонд арвайн соёолж, зөрөг цэцэг ордог бол WHEAT шар айргийн орцонд нэмэлтээр УЛААН БУУДАЙ гэх өвөрмөц, үнэтэй түүхий эд ордогоороо онцлог юм.



Савалгаа: 0.45л  
Спиртийн агууламж: 5%

БРЭНД ПОРТФОЛИО • Шар айраг



**Heineken**

Товч танилцуулга:  
Амстердам хотод анх үүсэн Жерард Адриан Хайнекен хэмээх үүсгэн байгуулагчийн нэрээр нэрлэгдсэн дээд зэрэглэлийн Heineken® брэнд нь 170 гаруй оронд борлуулагдаж байна. Чанар бол Heineken® брэндийн хамгийн чухал үзүүлэлт бөгөөд уламжлалт технологийн дагуу исгэсэн өөрийн нэрийн "А" хөрөнгийг ашиглан үйлдвэрлэдэг. Heineken® брэнд нь дэлхийд алдартай олон улсын хөгжим, кино, спортын арга хэмжээг дэмжин ажилладагаараа онцлог юм.

Савлагаа: 0.5л 0.33л  
Спиртийн агууламж: 5.0%



**Tiger**

Товч танилцуулга:  
1932 онд үйлдвэрлэж эхэлсэн Tiger шар айраг исгэлтийн онцгой технологи, амт чанараараа шалгарч өдгөө дэлхийн 70 гаруй орны сая сая хэрэглэгчдийн дуртай брэнд болоод ачанарын шалгалтын дор 500 гаруй цаг исгэдэг бөгөөд олон улсын нэр хүндтэй 40 гаруй шагналыг хүртсэн. Tiger нь Монгол улсад үйлдвэрлэгдэж хэрэглэгчдэд шинэхэнээрээ хүрдэг анхны, олон улсын, дээд зэрэглэлийн шар айраг бөгөөд ийм ч утгаараа Монголын хэрэглэгчдийн хувьд онцгой бүтээгдэхүүн юм.

Савлагаа: 0.33 л, 0.5 л  
Спиртийн агууламж: 5.0%



**Kaltenberg**

Товч танилцуулга:  
АПУ ХК Герман улсын Баварийн вангийн удмын зуун дамжсан туршлагыг шингээсэн улаан буудайн, шүүлтүүргүй шар айргийг Монголд анх удаа худалдаанд гаргаж байна. Kaltenbergийн өвөрмөц хөрөнгөөс үүдэн бүүдгэр харагддаг энэхүү улаан буудайн сонгодог шар айргийг үйлдвэрлэхэд хамгийн сайн чанарын түүхий эдийг ашигладаг. Амтат зөрөг цэцэг болон гадил жимсний өвөрмөц амттай энэхүү шар айргийг Баварийн өвөг дээдсээс уламжлагдан ирсэн технологиор үйлдвэрлэх бөгөөд 5.5%-ийн спиртийн агууламжтай.

Савлагаа: 0.5 л  
Спиртийн агууламж: 5.5%



**Kaltenberg special**

Товч танилцуулга:  
Баварийн Хаадын удмын Kaltenberg брэндийн шинэ гишүүн, Бавари мужийн баярын онцгой шар айраг болох Kaltenberg Spezial брэндийг 2017 онд зах зээлд нэвтрүүллээ. Баварын "Цэвэр Тунгалагийн Хууль"-ийн дагуу исгэсэн уг пиво нь Бавари мужийн Халлертау нутгийн сайн чанарын онцгой зөрөг цэцэг, дээд зэргийн арвайн соёлж, Kaltenbergийн шалгарсан хөрөнгөөр исгэсэн шүүлтүүртэй цайвар пиво юм.

Савлагаа: 0.5 л  
Спиртийн агууламж: 5.6%



**Алтан Говь**

Товч танилцуулга:  
Германы уламжлалт цэвэр тунгалаг /Reinheitsgebot/-ийн хуулийн дагуу исгэдэг, тансаг зэрэглэлийн "Алтан Говь" шар айргийг 2003 оноос үйлдвэрлэж эхэлсэн. Сэтгэл тайвшруулах увидас шингээсэн зөрөг цэцгийн хандтай, зөөлөн, амтлаг энэ шар айраг 5.1%-ийн спиртийн агууламжтай.

Савлагаа: 0.33 л, 0.45 л, 0.5 л, 5 л  
Спиртийн агууламж: 5.1%



**Нийслэл**

Товч танилцуулга:  
Зөв, соёлтой хэрэглээний илэрхийлэл болсон "Нийслэл" шар айргийг 1972 оноос үйлдвэрлэж эхэлжээ. Монголын ууган шар айргийн нэг "Нийслэл" брэндийг Герман технологиор шинэчлэж, 5.0%-ийн спиртийн агууламжтайгаар савлагааны өргөн сонголттой үйлдвэрлэж байна.

Савлагаа: 0.45 л, 0.5 л, 1.5 л, 2.5 л  
Спиртийн агууламж: 5.0%



**Сэрүүн**

Товч танилцуулга:  
Жинхэнэ LIGHT шар айраг "СЭРҮҮН" брэндийг шар айрагны дэвшилтат технологи СЭРҮҮН шүүлтийн системийг ашиглан, шинэ үеийн хэрэглэгчдийн хүсэл эрмэлзэлд нийцүүлэн үйлдвэрлэлээ. 90-н жилийн туршлага, шинэ үеийн шинэчлэлийг агуулсан "СЭРҮҮН" брэнд нь 4.8%-ийн спиртийн агууламжтайгаар савлагааны өргөн сонголттой үйлдвэрлэгдэж байна.

Савлагаа: 0.5 л  
Спиртийн агууламж: 5.5%

## СЭНГҮР

### Сэнгүр

Товч танилцуулга:  
Тайгер шар айргийн үйлдвэрийн Герман Брюмастерын ууган бүтээл, үндэсний брэнд Сэнгүр нь анх 2007 онд зах зээлд худалдаалагдаж эхэлсэн. Сэнгүр нь 2014 онд Дэлхийн шилдэг шар айргыг тодруулдаг "WORLD BEER AWARDS 2014" –с амт чанараараа шалгарч АЗИЙН ШИЛДЭГ ШАР АЙРАГ & АЛТАН МЕДАЛ хүртэж дэлхийн брэндүүдтэй өрсөлдөхүйц шар айраг гэдгээ олон улсад баталлаа. СЭНГҮР брэнд нь үргэлж шинэлэг, шинэ мэдрэмжийг хэрэглэгчдэдээ өгөхийг зорьдог юм.

Савлагаа: 0.45л 0.5л  
Спиртийн агууламж: 4.8%

### Сэнгүр White

Товч танилцуулга:  
Улаан буудайн шар айраг нь Герман, Бельги улсаас гаралтай бөгөөд энэ төрлийн шар айргийг "White beer" буюу Цагаан шар айраг хэмээн нэрлэдэг. СЭНГҮР WHITE нь шүүлтүүргүй мэт бүүдгэр өнгөтэй, энгийн шар айргаас илүү өтгөн, жүржийн өвөрмөц амттай юм.

Савлагаа: 0.45л 0.5л  
Спиртийн агууламж: 5%

## СЭНГҮР РАДЛЕР

Товч танилцуулга:  
Радлер гэдэг нь Германаар дугуйчин гэсэн утгатай үг юм. 1922 онд Германы Мюнхен хотын нэгэн паб-д 13000 дугуйчин зэрэг хүрэлцэн ирсэн ба пабд байсан шар айргийн нөөц хүрэхгүй байсан учир нимбэгний шүүстэй хольж өгсөн нь радлер хэмээх шинэ төрөл үүсэх эхлэлийг тавьсан гэдэг.

### Сэнгүр радлер Нимбэг

Товч танилцуулга:  
Арвайн соёолж, зөрөг цэцгийг цэнгэг уснаа хандлан исгэж, натурал НИМБЭГ жимсний жүүсээр баяжуулан үйлдвэрлэсэн СЭНГҮР РАДЛЕР нь 1.9% алкохолын агууламжтай, Монголд үйлдвэрлэсэн анхны радлер шар айраг бөгөөд давхар сэргээх онцгой мэдрэмжийг өгдөгөөрөө онцлогтой.

Савлагаа: 0.45л 0.5л  
Спиртийн агууламж: 1.9%

### Сэнгүр радлер Манго & тоор

Товч танилцуулга:  
Арвайн соёолж, зөрөг цэцгийг цэнгэг уснаа хандлан исгэж, натурал МАНГО болон ТООР жимсний жүүсээр баяжуулан үйлдвэрлэсэн СЭНГҮР РАДЛЕР нь 1.9% алкохолын агууламжтай, Монголд үйлдвэрлэсэн анхны радлер шар айраг бөгөөд давхар сэргээх онцгой мэдрэмжийг өгдөгөөрөө онцлогтой.

Савлагаа: 0.45л 0.5л  
Спиртийн агууламж: 1.9%





## БРЭНД ПОРТФОЛИО • Ус, ундаа, шүүс

### АПУ Цэвэр ус

Товч танилцуулга:  
Монголын анхны савласан цэвэр ус болох АПУ цэвэр ус нь Герман улсын шилдэг техник, технологийг ашиглан 4 давхар шүүлтүүрээр шүүж савласан хамгийн сайн шингэн нөхөх цэвэр ус юм.



Савлагаа: 0.33 л, 0.5 л, 1.5 л ПЭТ

### Оргилуун

Товч танилцуулга:  
Оргилуун бол эх орны цэвэр тунгалаг усаар хүний өдөр тутмын хэрэглээнд зориулан бүтээгдсэн брэнд юм. Уг хийжүүлсэн ус нь хүний биеийн шингэнийг нөхөх чанараараа эрүүл мэндэд ач тустай бөгөөд чанарын өндөр түвшинд бүтээгддэг. Оргилуун хийжүүлсэн ус нь кальцийн ион, сульфат ион, хлорын ион, калийн ион, магнийн ион зэрэг нэгдлүүдийг агуулдаг тул хүний биеийн эрдсийн агууламжийг нөхөх үнэт чанартай бүтээгдэхүүн юм. Уг хийжүүлсэн ус нь амны цангааг тайлж, сэтгэл сэргээж, эрч хүчтэй мэдрэмжийг төрүүлдэг.



Савалгаа: 0.33л (лааз), 0.5л (ПЕТ), 1.0л (ПЕТ)



### Тэрэлж

Товч танилцуулга:  
1981 оноос хойш худалдаалагдаж буй Тэрэлж хийжүүлсэн ундаа нь найрлагандаа бие, сэтгэлийг сэргээх үйлчилгээтэй алтан гагнуур, ганга өвс, цээний үндэс зэрэг зөвхөн байгалийн гаралтай түүхий эдийн хандыг агуулсан. Онцгой амт, анхилуун үнэр, тусгай найрлагаараа бусдаас ялгарч хоол боловсруулах эрхтэн, бөөрний үйл ажиллагааг сайжруулах үйлчилгээтэй онцлог бүтээгдэхүүн юм. "Байгалийн жинхэнэ АМТ"



Савлагаа 1.5 л ПЭТ

### Сэлэнгэ

Товч танилцуулга:  
1981 оноос хойш худалдаалагдаж буй Сэлэнгэ брэнд нь цэвэр байгалийн гаралтай, найрлагандаа нохойн хошуу, ганга өвс, чихэр өвс, шилмүүс зэрэг анхилуун үнэртэй, сэргээх үйлчилгээтэй байгалийн гаралтай түүхий эдийг агуулсан тул амьсгалын зам болон цусны эргэлтийг сайжруулах, бие махбодийг сэргээх үйлчилгээтэй. "Байгалийн жинхэнэ АМТ"



Савлагаа 1.5 л ПЭТ

### Фрутта

Товч танилцуулга:  
Германы технологи ашиглаж, эх нутгийн гүнийн цэнгэг ус, Европын байгалийн гаралтай түүхий эдээр үйлдвэрлэсэн "Фрутта" брэнд нь сэтгэл сэргээх бүтээгдэхүүн юм. Эрүүл хүнсний олон улсын стандартад нийцсэн, бүх насны хүмүүст зориулсан "Фрутта" ундаа, жимсний шүүсийг 2009 оноос үйлдвэрлэж байна.



Савлагаа: Тетрапак 1 л

## БРЭНД ПОРТФОЛИО • Сүү, Сүүн бүтээгдэхүүн



### Цэвэр сүү

Товч танилцуулга:  
Монгол үнээний шинэхэн сүүг орчин үеийн шилдэг технологи болох хэт өндөр температураар ариутгаж, Олон улсын чанар, эрүүл ахуйн ISO 22000 стандартын дагуу үйлдвэрлэсэн "Цэвэр сүү"-г хадгалалт даах Тетра Пак савлагаатайгаар 2006 онд худалдаанд гаргасан. "Цэвэр сүү" нь цөцгий мэт өтгөн, тэжээллэг бөгөөд хүний биед шаардлагатай амин дэм, эрдэс бодисуудаар баялаг, дахин боловсруулахгүйгээр шууд ууж хэрэглэхэд болон сүүтэй цай чанаж уухад тохиромжтой бүтээгдэхүүн юм.

Савлагаа: Тетрапак 1 л



### Дээж сүү

Товч танилцуулга:  
Дээж сүү бол малчид болон фермерүүдээс сүүгээ авч орчин үеийн технологи тоног төхөөрөмжөөр нам температурт ариутган савласан брэнд юм. Хэрэглэхэд эвтэйхэн өргөн амсар бүхий пюрпак савлагаанд савлагдсан 100% үнээний шингэн сүү юм. Орц найрлага: 100% Үнээний сүү Хэмжээ: 1 литр Тослог: 3,2% Савлагаа: Пюрпак Хадгалах хугацаа: 14 хоног

Савлагаа: Тетрапак 1 л



### Дээж ааруул

Товч танилцуулга:  
Дээж ааруул жимстэй болон энгийн гэсэн 2 төрөлтэй. 22 хувийн тослог агуулсан үнээний цэвэр сүүний аарцаар хийсэн тул уураг болон эрдсээр баялаг. Бүтээгдэхүүний савлагаа нь агаар нэвтрүүлэх болон дахин ашиглах түгжээтэй бөгөөд хүнсний будаг, амт оруулагч агуулаагүй эрүүл бүтээгдэхүүн юм.

Савлагаа: 400 гр, 900гр



### Дээж тараг

Товч танилцуулга:  
Дээж тараг нь 100% үнээний сүүгээр бүрсэн, тослог багатай, чихэргүй, амьд бактери 1гр тарганд 10 саяас дээш агуулагдсан. Тослог багатай чихэргүй учраас илүүдэл жингээс урьдчилан сэргийлэхэд тустай, Бүх насныхан хэрэглэхэд тохиромжтой.

Орц найрлага: Үнээний сүү, хөрөнгө  
Тослог: 1,5%  
Хадгалах хугацаа: 21 хоног

Савлагаа: Тетрапак 1 л



### Дээж тараг бор саахартай

Товч танилцуулга:  
Дээж тараг нь 100% үнээний сүүгээр бүрсэн, тослог багатай, бор элсэн чихэртэй, амьд бактери 1гр тарганд 10 саяас дээш агуулагдсан. Бүх насныхан хэрэглэхэд тохиромжтой.

Орц найрлага: Үнээний сүү, хөрөнгө  
Тослог: 1,5%  
Хадгалах хугацаа: 21 хоног

Савлагаа: Тетрапак 1 л



### Дээж цөцгийн тос

Товч танилцуулга:  
"Дээж" цөцгийн тос нь үнээний цэвэр сүүний цөцгийг орчин үеийн техник технологиор боловсруулан үйлдвэрлэсэн өрөм мэт цөцгийн тос юм. Цөцгийн тос нь биологийн идэвхит бодис болох фосфолипид, тосонд уусдаг амин дэмүүд (А, Е, D), бетта каротин, нүүрс ус, эрдсээр баялаг тул хоол хүнсэндээ хэрэглэхэд тохиромжтой.

Хэмжээ: 180гр; Тослог: 82%; Хадгалах хугацаа: 6 сар

БРЭНД ПОРТФОЛИО • Сүү, Сүүн бүтээгдэхүүн

# САЙН АКТИВ



Товч танилцуулга:  
Монголын зах зээлд анх удаа дэлхийн алдарт Кристиан Хансен компанийн патенттай LGG пробиотик хөрөнгөөр бүрэгдсэн Сайн Актив уудаг йогурт 2019 оны 4 сар худалдаанд гарсан билээ. Сайн Актив уудаг йогурт нь 3 төрлийн амттай

1. Оригинал тараг
2. Ванилла & чиа үртэй йогурт
3. Хар чавга & овъёостой йогурт

Хэрэглэгчдийнхээ хэрэгцээнд нийцүүлэн 290 гр болон 870 гр-ын 2 төрлийн савалгаатай зах зээлд танилцуулагдаад байна. Амтны хувьд тансаг зөөлөн амт бүхий LGG пробиотик хөрөнгөөр хийгдсэн нь гол давуу тал. Сайн Актив йогуртны LGG пробиотик хөрөнгөнд агуулагдах идэвхтэй, ашигтай бичил биетний тоо нь 1 граммд 100 сая (10<sup>8</sup>). Мөн энэхүү хөрөнгөнд агуулагдах L.Rhamnosus ашигтай бичил биет нь бүх насныхны дархлалын системийг дэмжих, ходоод гэдэсний хэвийн орчинг хангаж, улмаар бие организмыг идэвхтэй/ эрч хүчтэй болгох давуу талтай. Энэ үйлчилгээ нь LGG пробиотик хөрөнгөний хувьд хамгийн олон удаагийн туршилт судалгаагаар батлагдсан бөгөөд бусад пробиотик хөрөнгөнүүдээс ялгарах давуу тал нь юм.



Хэмжээ: 290 гр, 870 гр Тослог: 1,5%  
Савлагаа: Пэт Хадгалах хугацаа: 21 хоног



## Сайн Д амин дэмтэй сүү

Товч танилцуулга:  
Тослог багатай, Д амин дэмээр баяжуулсан Сайн Д амин дэмтэй сүүг эрүүл хооллолтыг эрхэмлэдэг, биеийн тамир, фитнесээр хичээллэдэг хүмүүс өдөр тутамдаа ууж хэрэглэхэд тохиромжтой. Сайн Д амин дэмтэй сүү нь 250мл, 500мл савлагаатай, шууд уух зориулалттай төдийгүй та бидний өдөрт авах Д амин дэмийн зохистой хэмжээний 250мл-300IU буюу 50%, 500мл-600IU буюу өдрийн бүтэн нормыг агуулдаг.

Хэмжээ: 250 гр, 500 гр Тослог: 1,5% Савлагаа: Эколин, Элопак



## Сайн ногоо жимсний хослол

Товч танилцуулга:  
Сайн ногоо жимсний хослол йогурт нь 1. Бууцай, кивитэй йогурт - тослоггүй, нэмэлт сахаргүй, 2. Лууван, жүржтэй йогурт - 2,5%-ийн тослогтой, 3. Хүрэн манжин, ногоон алимтай йогурт - 2,5%-ийн тослогтой гэсэн 3 төрөлтэй. 500гр аар савлагдсан элопак савалгаатай бөгөөд амин дэм пробиотикоор баялаг учир эрүүл мэндэд олон талын ач тустай. Ногоо идэх дургүй хүүхдүүд болон ажил хэрэгч, завгүй хэрэглэгчдэд тохиромжтой амин дэм, пробиотикоор баялаг йогурт юм.

Хэмжээ: 500 гр Тослог: 2,5%, 0% Савлагаа: Элопак Хадгалах хугацаа: 21 хоног

## БРЭНД ПОРТФОЛИО • Сүү, Сүүн бүтээгдэхүүн

### Сайн бифидо тараг

Товч танилцуулга:  
Сайн бифидо тарагны 1гр тутамд агуулагдах ашигтай бичил биетний тоо нь  $10^{12}$  буюу 100,000,000 ба таргийг гаргаж авахын тулд бүрэлдэх явцыг нэмэлт бифидо бактериар баяжуулдаг. Сайн бифидо таргийг тогтмол хэрэглэснээр ходоод гэдэсний хэвийн орчинг хангах, дархлаа дэмжих зэрэг олон талын ач тустай.



### Сайн зөөхий

Товч танилцуулга:  
Цэвэр цөцгийг хөрөнгөлж хийсэн, хүнсний нэмэлт агуулаагүй, хүний биед төгс шингэдэг Сайн зөөхий нь B2, B12, PP, E, C, A аминдэмээр баялаг амьд органик бүтээгдэхүүн юм.



Хэмжээ: 450гр, 350гр Тослог: 20% Савлагаа: Эколин, аяган савалгаа Хадгалах хугацаа: 21 хоног

### Сайн жимстэй йогурт

Товч танилцуулга:  
Сайн жимстэй йогурт нь 1. Гишүүнэ интоортой, 2. Ойн жимстэй, 3. Гүзээлгэнэтэй гэсэн 3 төрөлтэй бөгөөд 2,5%-ын тослогтой, 450 граммын савалгаатай худалдаалагдаж байна. Үнээний цэвэр сүүгээр бүрсэн, шинэхэн жимсний агууламжтай, пробиотикоор баялаг Сайн жимстэй йогурт нь эрүүл мэнддээ анхаардаг хүн бүрийн хэрэглээнд тохирох бүтээгдэхүүн юм. 1гр тутамд агуулагдах ашигтай бактерийн хэмжээ  $10^{17}$  зэрэг буюу 10,000,000 бактери. Сайн жимстэй йогуртын Эколин савалгаа нь байгаль орчинд ээлтэй Монголын анхдагч савалгаа юм.



## БРЭНД ПОРТФОЛИО • Сүү, Сүүн бүтээгдэхүүн

### Мааму йогурт

Товч танилцуулга:  
Тоортой, нэрстэй, гүээлэгэнэтэй гэх 3 төрлийн йогуртыг үйлдвэрлэдэг. Мааму йогуртанд агуулагдах уураг нь оюун ухааныг тэлж, IQ өндөр болгоно.



Хэмжээ: 200мл; Савлагаа: Эколин; Хадгалах хугацаа: 21 хоног

### Мааму сүү

Товч танилцуулга:  
Гадил, гүээлэгэнэ, шоколад болон цэвэр гэсэн 4 төрлийн амтлаг сүүг бяцхан хэрэглэгчдэдээ зориулан үйлдвэрлэж байна. Сүү нь Ханиад томуунаас сэргийлж, хүүхдийн өсөлтийг дэмжинэ, кальциар баялаг тул шүд, ясны бэхжилтэд сайн гээд өсөж яваа хүүхдүүдэд тун тохирсон бүтээгдэхүүн юм.



Хэмжээ: 125мл, 180мл; Тослог: 1.5%; Савлагаа: Эколин; Хадгалах хугацаа: 3 сар

### Мааму шүүс

Товч танилцуулга:  
Мааму шүүсэн дэх концентрацийн хэмжээ бусад шүүснийхээс бага тул хүүхэд уухад нэн тохиромжтой. Алим, олон жимст, аньс, чацаргана гэх төрлүүдтэй. Эдгээр жимснүүд нь амин дэм, эрдсээр ихээр агуулсан учир дархлааг дэмжинэ. Шүүсэн дэх сахарын хэмжээ бусад шүүснийхээс харьцангуй бага тул хүүхэд уухад нэн тохиромжтой.



Хэмжээ: 180мл, 200мл; Савлагаа: Эколин; Хадгалах хугацаа: 9 сар

## БРЭНД ПОРТФОЛИО • Импортын брэнд

### Glen Grant-Single Malt

Товч танилцуулга:  
Шотланд улсын Спесайд (Speyside) бүсэд 1840 онд албан ёсоор ах дүү Grant үйлдвэрээ байгуулан тус брэндийг үүсгэн байгуулжээ. Өдгөө 200 гаруй жилийн туршлагад үндэслэн урласан тус брэнд нь 2015 оноос хойш 3-н жилийн дараалан "Jim Murray's Whisky Bible"-аар Шотландын хамгийн шилдэг вискигээр шалгарсан. Маш өндөр зэрэглэлийн "Single Malt" буюу нэг амууны виски.



Савалгаа: 0.7л  
Спиртийн агууламж: 43%

### Wild Turkey Bourbon

Товч танилцуулга:  
Wild Turkey АНУ-ын Кентаки мужаас гаралтай 150 жилийн түүхтэй жинхэнэ бурбон виски. Гар аргаар хийсэн цэвэр царс модон торхонд "Alligator char" буюу хамгийн гүнзгий шарлагыг хийж, орцоо гар аргаар сонгон хольц найрлага бүр дээр исгэлтийн Дэлхийн вискиний мастеруудын дунд домог болсон мастер "Jimmy Russell" тусгайлан анхаарал тавьж урлан 5-8 жил насжуулан гаргасан бүтээгдэхүүн. Карамель болон царс модны үнэртэй, хүний хоолойд торохгүй торгомсог. Амтны хувьд "Smoked" буюу гал дээр утсан зүйл, ваниль болон бага зэргийн исгэлэн амттай.



Савалгаа: 1л, 0.7л  
Спиртийн агууламж: 40.5%

### Tenjaku-Japanese Whisky

Товч танилцуулга:  
Арлын Япон улсын Фүжи галт уулын чулуугаар дамжин газрын гүнээс оргилон гарч ирсэн цэнгэг эрдэст ус, гар аргаар сонгосон арвайн соёолжоор исгэж хийсэн дээд зэргийн чанартай виски. Япон соёлын уйгагүй төгс бүтээлч зан чанарыг эрхэмлэн өөрийн бүтээлдээ байнга шингээдэг алдар мастер Kenji Watanabe-ийн бүтээсэн урлал. Tenjaku нь дээд зэргийн япон виски.



Савалгаа: 0.7л  
Спиртийн агууламж: 40%

### Espolon-Tequila

Товч танилцуулга:  
Espolon текилла нь Мексик улсын өндөрлөг уулсаар хүрээлэгдсэн Jalisco хөндийд 16-р зуунаас хойш текилла урлаж ирсэн онцгой орцыг ашиглаж бүтээдэг. Тус текилла дарсыг Уулын энгэрийн хязгаарлагдмал талбайд 8-12 жил ургасан 100%-ын "Blue Agave" буюу "Цэнхэр Агава" ургамлаар урласан. Тус брэнд нь Мексик улсын соёлыг харуулан тус улсын билэг тэмдэг болсон азарган тахианы залаагаар өөрсдийн брэндээ анх нэрлэн гаргажээ. Espolon брэнд нь 100% цэнхэр агава ургамлаар хийгдсэн маш өндөр зэрэглэлийн чанартай текилла.



Савалгаа: 0.75л  
Спиртийн агууламж: 40%

### Jagermeister

Товч танилцуулга:  
1935 онд Curt Mast өөрийн анчин найзууддаа зориулж бүтээсэн бүтээгдэхүүн. ХБНГУ-д үйлдвэрлэгдсэн Jagermeister бүтээгдэхүүнийг 56 нэр төрлийн ургамлаас гаргаж авдаг бөгөөд энэ нь өвөрмөц онцлогтой баялаг түүхтэй 35%ийн хатуулагтай ликёр. Бүтээгдэхүүн нь лонхонд савлагдах хүртлээ 1 жил модон торхонд хадгалагддаг. Тус бүтээгдэхүүнийг цэв хүйтнээр (-18 градус) шууд хэрэглэнэ.



Савалгаа: 1л, 0.7л, 0.04л,  
Спиртийн агууламж: 35%

## БРЭНД ПОРТФОЛИО • Импортын брэнд



### Aperol Aperitivo

Товч танилцуулга:  
Итали улсад 1919 онд үүссэн Aperol брэнд нь жүржийн амттай зөөлөн аперитив. Нарлаг зуныг санагдуулам тод жүржийн өнгөтэй энэхүү бүтээгдэхүүн нь Aperol Spritz коктейль хэлбэрээр 2010 оноос хойш өнөөг хүртэл дэлхий зах зээлд өндөр амжилттай нэвтэрч 2019 оны хамгийн их борлуулагдсан коктейль болон шалгарсан байна. Өдгөө 100 нас хүрч буй бөгөөд оройг эхлүүлэхэд тохиромжтой шилдэг бүтээгдэхүүн.

Савалгаа: 0.7л  
Спиртийн агууламж: 11%



### Campari Aperitivo

Товч танилцуулга:  
Итали улсын дэлхийд танигдсан хамгийн алдартай аперитив нь Campari бөгөөд тус бүтээгдэхүүний маш өндөр зэрэглэлд чандлан хадгалдаг нууц жор нь 1860 онд Gaspare Campari зохион бүтээжээ. Тус брэнд нь дэлхийд маш өвөрмөц хайрын түүхээс үүсэлтэйгээр танигдсан бөгөөд хайр дурлал, хүсэл эрмэлзлийн билэг тэмдэг болсоор өдийг хүртэл нэрээ дэлхийн зах зээлд тунхаглаж байна. Дэлхийн топ 10 коктейлийн дийлэнхийн орцод ордог бөгөөд коктейлийн соёлыг Campari-гүйгээр төсөөлөхийн аргагүй.

Савалгаа: 0.75л  
Спиртийн агууламж: 25%



### Bulldog-Gin

Товч танилцуулга:  
BULLDOG джин нь Английн алдарт Уинстон Черчилль-д гаргасан бүтээгдэхүүн. 8-н улсаас нарийвчлан сонгон гар аргаар хурааж авсан 12 төрлийн ургамлын хандыг төгс зохицуулж олон жилийн баялаг туршлагаар Англи улсад үйлдвэрлэдэг. BULLDOG джин нь маш өвөрмөц дээд зэрэглэлийн бүтээгдэхүүн.

Савалгаа: 0.7л  
Спиртийн агууламж: 40%



### Grand Marnier Orange Cognac

Товч танилцуулга:  
1827 онд Франц улсын алдар мастер Patrick Ragueaud-ын гараар урласан 200 жилийн түүхтэй брэнд. Франц улсын нэрийн хуудас болсон бүтээгдэхүүний нэг бөгөөд 6 үеэрээ дамжин нууцалсан жороор урласан, тансаг зэрэглэлийн Коньякыг Карибын тэнгисийн арлуудаас авчирсан зэрлэг жүржтэй хольж гаргасан ликёр.

Савалгаа: 0.7л  
Спиртийн агууламж: 40%



### Cinzano-Vermouth

Товч танилцуулга:  
Cinzano брэндийг 1757 онд ах дүү Cinzano-ын гэр бүл Итали улсын Турин хотод анх зохион бүтээжээ. Тус брэнд нь дэлхийн хамгийн анхны вермут дарс бөгөөд Итали улсын нэгэвхэн таних билэг тэмдэг болсон. Бүтээгдэхүүний хувьд 3 төрөлтэй бөгөөд Cinzano Bianco, Cinzano Rosso, Cinzano Extra Dry гэсэн төрлүүдээр хэрэглэгчдийн гар дээр хүрч байна.

Савалгаа: 1л  
Спиртийн агууламж: 15%, 18%



### Appleton Estate-Rum

Товч танилцуулга:  
Ямайка улсын ром дарсны алдарт өлгий нутаг болох Nassau хөндийн үржил шимтэй зурхэн хэсэгт The Appleton-ын эзэмшил газар нь оршдог. Тус эзэмшил газарт урлан гаргаж авдаг Appleton Estate ром дарс нь 15 төрлийн өрийн онцлог, үнэр, амт, насжилт бүхий ром дарсны хамгийн шилдгийг сонгож найруулдаг. Хамгийн багадаа 4 жил даран урладаг бөгөөд дэлхийн бартендерүүдийн өндөр зэрэглэлийн ром дарсны номер нэг сонгог.

Савалгаа: 0.75л  
Спиртийн агууламж: 40%

## БРЭНД ПОРТФОЛИО • Импортын брэнд

### Maison Castel

Товч танилцуулга:

Бид Европын №1 төдийгүй Дэлхийн №3 дах том дарс үйлдвэрлэгч Castel Freres группийн нэрийн дарс болох MAISON CASTEL брэндийн 24 нэр төрлийг бид 2019 оноос эхлэн Монголын зах зээлд танилцуулсан билээ.

Францын дарсны өлгий нутаг болох Бордо мужид үйлдвэрлэгдэж дэлхийн 130 гаруй орнуудад экспортлогддог алдартай брэнд билээ.



Үйлдвэрлэгч улс: Франц улс, Бордо муж  
Нэр төрөл: 5 ангиллын 24 нэр төрөл  
Савлагаа: 0,75



### Faustino

Товч танилцуулга:

Испани улсын хамгийн чанартай, алдартай дарснууд гардаг РИОХА мужийн нүүр царай бүхий FAUSTINO брэндийг бид 2019 онд Монголдоо анхлан оруулж ирж танилцуулсан билээ.

Испани улсын Хамгийн Шилдэг Улаан дарс гэдэг хүндтэй нэрийг эзэмшдэг тус брэнд борлуулалтаараа Испани улсын хамгийн их борлуулалттай дарс төдийгүй дэлхийн 100 гаруй улсад боруулагддаг билээ.

Үйлдвэрлэгч улс: ИСПАНИ улс  
Нэр төрөл: 4 нэр төрөл  
Савлагаа: 0,75



### Vina Maipo

Товч танилцуулга:

Чили улсын хамгийн том дарс үйлдвэрлэгч болох CONCHA Y TORO компанийн VINA MAIPO брэндийг бид 2019 онд Монголын зах зээлд оруулж ирсэн.

Чили улсын хамгийн алдартай дарсны хөндий болох MAIPO Valley-д тариалсан усан үэмийн шигшмэл сортуудаар үйлдвэрлэсэн эдгээр дарснууд дэлхийн 100 гаруй орны дарс таашаагчдын хэдийнээ танил болсон брэнд билээ.

Үйлдвэрлэгч улс: Чили улс  
Нэр төрөл: 4 нэр төрөл  
Савлагаа: 0,75



## БРЭНД ПОРТФОЛИО • Импортын брэнд

### Albert Bichot

Товч танилцуулга:

Albert Bichot компани нь 1831 оноос Францын эзэнт гүрний Хаад, Язгууртнуудын дарсыг үйлдвэрлэдэг байсан гэр бүлээс эхлэлтэй бөгөөд өнөөдөр бдах үе дээрээ Дэлхийн тансаг зэрэглэлийн, үнэтэй дарс үйлдвэрлэгч алдартай компани боллоо өсч тэлсэн билээ.

Францын дээд зэрэглэлийн дарсны өлгийн нутаг гэгддэг Бургунди мужид өөрсдийн эдлэн газруудад ургасан ховор, өндөр зэрэглэлийн усан үзмийн сортуудаар хийгддэг эдгээр дарснууд нь маш цөөн тоогоор үйлдвэрлэгддэг бөгөөд бид эдгээр ховор дарснуудыг Монголын дарсны хэрэглэгч нарт 2019 оноос эхлэн хүргэж эхэллээ.



Үйлдвэрлэгч улс: Франц улс, Бургунди муж  
Нэр төрөл: 14 нэр төрөл  
Савлагаа: 0,75



### Vitral

Товч танилцуулга:

Чили улсын хамгийн том дарс үйлдвэрлэгч болох CONCHA Y TORO компанийн VITRAL брэндийг бид 2019 онд Монголын зах зээлд оруулж ирсэн.

Шинэ Дэлхийн дарснуудын томоохон төлөөлөл болох Vitral брэнд нь Чили дарсны шинэ үеийн томоохон төлөөллүүдийн нэг юм.

Үйлдвэрлэгч улс: Чили улс  
Нэр төрөл: 4 нэр төрөл  
Савлагаа: 0,75



### La Chamiza

Товч танилцуулга:

Аргентин улсын хамгийн алдартай усан үзмийн сорт болох MALBEC сортоор үйлдвэрлэсэн брэнд.

Өөрийн улсын билэг тэмдэг спорт болох Морин Поло-г логондоо залсан La Chamiza брэнд нь тус улсын алдартай брэндүүдийн нэг билээ.

Үйлдвэрлэгч улс: Аргентин улс  
Нэр төрөл: 4 нэр төрөл  
Савлагаа: 0,75



4

**ТОГТВОРТОЙ  
БАЙДАЛ**

"One day of Mongolia" арга хэмжээ  
2019 оны 12-р сарын 06-ны өдөр. ОХУ, Казань хот. Казань Палас зочид буудал

## ХҮНИЙ НӨӨЦ БА БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ

### ФС Улаанбаатар багтай хамтран ажиллалаа

2018 онд компанийн нэгдэн нийлэлтийн хүрээнд “Нэг гэр бүл, нэг зорилго” концепцийн дагуу төлөвлөгөө боловсруулан ажиллаж ажилтан бүр нэг гэр бүл шиг, нэг зорилгын төлөө нэгдмэл байх, нэг үзэл санаа зорилгын төлөө нэгдэх, бие биенээ илүү ойлгох, таньж мэдэхэд чиглэсэн бол 2019 онд бид Байгууллагын соёлын гол чухал үйл ажиллагаануудад ач холбогдол өгч ажиллалаа. Үүний үр дүнд, нийт ажилтнуудын 95 хувийн хамрагдалттай оролцсон байгууллагын соёлын судалгааны дүн, өмнөх онтой харьцуулахад өссөн сайн үзүүлэлттэй гарсан байна. Байгууллагын судалгааны үр дүнгээс товчхон дүгнэхэд, манай ажилтнууд компанийн “Удирдлагуудын арга барил”, “Ажиллах орчин нөхцөл” болон “Ажилтны хөгжил” гэсэн бүлэг үзүүлэлтүүд өмнөх оноос илүү өндөр хувийн өсөлттэй байгаагаар үнэлсэн нь эдгээр үзүүлэлтүүд жил бүр чанаржин, сайжирч байгааг илэрхийлж байна.

2019 оны хүний нөөцийн бодлогын хэрэгжүүлэлтийн хүрээнд: “Чадварлаг ажилтнуудаар бизнесийн зорилгод өндөр гүйцэтгэлтэйгээр хүрэх” бодлогын хүрээнд дараах бодлого, журмуудыг амжилттай нэвтрүүлэн хэрэгжүүлж эхэлсэн.

- Гүйцэтгэлийн удирдлагын журам
- Гол ажилтныг тодорхойлох, гол ажлын байрны залгамж халааг бэлтгэх тухай журам
- Алба тус бүрийн байгууллагын соёлд оруулж болох хувь нэмрийг ярилцах, ажилтан нэг бүрийн саналд тулгуурласан сайжруулах төлөвлөгөөг боловсруулах багийн уулзалт, хэлэлцүүлэг

### Хүний нөөцийн хэмжүүр

- Хүний нөөцийн нэгдсэн тайлан тоон үзүүлэлт болон баримт бичгийн загварыг шинээр үүсгэн FTE хэмжиж эхэлсэн.
- Хүн ба байгууллагыг хөгжүүлэхэд оруулах удирдлагуудын хувь нэмрийг тооцох, үнэлэх зорилгоор People Development гэсэн үзүүлэлтийг KPI-н нэг хэсэг болгон хэрэгжүүлсэн.
- Ажиллах хүчний зардлын төвийг бий болгон ажилтан бүрт код үүсгэж, ажилтантай холбоотой зардлыг хянах, бүртгэх болон төсөвлөх ажлыг хэрэгжүүлсэн.

### Сургалт хөгжил

АПУ компанийн хамт олон олон улсад нэвтрэн хэрэгжиж буй дэвшилтэт техник технологи, үйл ажиллагааны онцлог, арга барилууд, төсөл хөтөлбөрүүдийг нэвтрүүлэн хэрэгжүүлсээр байна. Эдгээрээс дурьдвал:

- Олон улсад хэрэгжиж буй Бүтээмжийн удирдлагын цогц системийг бүх үйлдвэрүүдэд хэрэгжүүлж, одоогийн процесс үйл ажиллагааг оновчлон, сайжруулахын зэрэгцээгээр үйлдвэрийн ажилтнууд олон улсын дүн шинжилгээ хийх, боловсруулах аргачлалыг хийхийн зэрэгцээгээр түүнд үндэслэн бодитоор хэрэгжүүлэн туршлагажин, суралцаж байна.
- Хайнекен компанийн Heineken First Line Managers Development Program буюу Анхан шатны менежерүүдийг хөгжүүлэх хөтөлбөрийг чиг үүрэг эрхэлсэн захирлуудын тусламжтайгаар боловсруулалт хийж, захирлууд сургагч багшаар ажиллан, удирдах түвшний 90 ажилтнуудыг 4 сарын хугацааны цогц сургалтаар хөгжүүлэн, сургасан.
- Хүний нөөцийн багаас санаачлан хэрэгжүүлж буй People Leader сургалтыг 2 дахь жилдээ зохион байгуулж, энэ удаад албадын дарга нарт компанид хэрэгжүүлж буй хүний нөөцийн бодлого журмын зохицуулалт, уялдаа холбоогоор ажилтнуудаа зөв, үр дүнтэйгээр удирдахад дэмжиж, сургасан.

АПУ компани нь 2019 онд ажилтнуудынхаа хөгжлийн хүрээнд ажлын байранд болон хувь хүний мэргэжлийн болон ерөнхий үр чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн 9 гадаад улс руу сургалт, дотоод болон гадны байгууллагаас авсан 791 сургалт авсан ба нийт 3684 цагийн сургалтанд 10305 ажилтанг хамруулж амжилттай зохион байгуулсан (давхардсан тоогоор).

### Ажилтнуудыг идэвхжүүлэх

2019 онд бид Байгууллагын соёлын гол чухал үйл ажиллагаануудад ач холбогдол өгч, ажилтнуудад чиглэсэн олон арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.

Ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт хангамж, эрүүл мэндийн хөтөлбөрүүдэд 13,8 тэрбум төгрөг • Урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээ, шагнал урамшууллын үйл ажиллагаанд 3,3 тэрбум төгрөг • Сургалт хөгжлийн үйл ажиллагаанд 656 сая төгрөг тус тус төсөв зарцуулсан байна.

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН



### ФС Улаанбаатар багтай хамтран ажиллалаа

Монголын хөл бөмбөгийн дээд лигт чансаагаар тэргүүлэгчдийн нэг ФС Улаанбаатар хотын хөл бөмбөгийн шигшээ багтай АПУ ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллаж ирсэн. 2019 оны хувьд ФС Улаанбаатар баг нь дээд лигт амжилттай тоглолтуудыг өрнүүлснээс гадна, Дэлхийн хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний урьдчилсан шатны тоглолтуудад уг багийн 4 гишүүн улсын шигшээ багт багтаж өөрсдийн гайхалтай ур чадваруудыг харуулсан билээ. Мөн АПУ ХК-ийн экспортын ажлын хүрээнд БНХАУ-ын Хөх хотын шигшээ багтай найрсаг тоглолт хийхээр зуны төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна.

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН

**Зөв Зохистой Соёлтой Хэрэглээ!**

Жил бүр Монгол Улсад орчин цагийн амьд хөгжмийн гайхамшгийг мэдрүүлж, залуу үеийн шинэ давлагаа, шинэ өнгө төрхийг илтгэдэг Play Time хөгжмийн наадамд АПУ ХК нь хамтран ажиллаа. Залуу үеийн дунд согтууруулах ундааны зохистой хэрэглээг таниулж, соёлын төвшинг ахиулах, олон талын сэтгэлгээний боловсролыг Green Zone байгуулан 3 өдрийн турш entertainment хөтөлбөрүүдээр дамжуулан хүргэсэн билээ. Бидний хувьд олон улсын ХАЙНЕКЕН компанийн үзэл баримтлал, зөв зохистой хэрэглээний тухай хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлж байна.

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН



## Монгол оюуны чадамжийг дэлхийд дахин баталлаа

Монголын оюун ухааны академитай хамтран ажиллаж залуу үеийг оюуны спортоор хичээллэх, олон улсад өрсөлдөх боломжийг олгоход өөрсдийн хувь нэмрээ оруулж тив дэлхийн томоохон тэмцээнүүдэд тамирчдаа дэмжин ажиллаа. Тухайлбал бидний дэмжиж хамтран ажилласан У.Солонго тамирчин нь Олон улсын ой тогтоолтын холбооны “Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн” -ээс 1 мөнгө, 4 хүрэл мөн дэлхийн ой тогтоолтын холбооны “Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн” -ээс 2 хүрэл медаль тус тус хүртсэн билээ. Эдгээр нэр хүндтэй хоёр том холбооны амжилтуудаас гадна БНХАУ-д зохиогдсон ой тогтоолтын дэлхийн аварга шалгаруулах тэмцээний үеэр хамгийн дээд цол болох “ОЛОН УЛСЫН ИХ МАСТЕР” цолын болзол хангаад байна.

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН

**Smiling Hearts арга хэмжээ өнгө нэмлээ**

АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга Пүрэвийн Батсайханы санаачилгаар “Бяцхан Хуандай ТББ”-тай хамтран “Smiling Hearts” буюу хүүхэд багачуудад урам зориг, итгэл найдвар бэлэглэх зорилготой сайн үйлсийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Уг ажлын хүрээнд Нийслэлийн Хан-Уул, Сонгино-Хайрхан дүүргийн 400 гаруй зорилтот бүлгийн хүүхдүүдийг хамруулж нэгэн өдрийг хамтдаа дуулж бүжиглэж, тоглож мартагдашгүй дурсамжийг бүтээсэн билээ.

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН



### Гэрэл асаая

Хүүхэд бүрийн зурх сэтгэлд гэрэл түгээх зорилготой “ГЭРЭЛ АСААЯ” шинэ жилийн баярыг АПУ компани “Ид Шидийн Орон 2” төвтэй хамтран амжилттай зохион байгууллаа. Бидэнтэй хамтран ажилладаг мянга мянган харилцагчдынхаа нэрийн өмнөөс ирсэн хүүхэд бүрт бэлэг гардуулж, дуу бүжиг, хөгжөөнт тоглоом, баяр хөөр, аз жаргалаар дүүрэн хөтөлбөрөөр хүүхэд багачууддаа бэлэг барьсан. “Гэрэл асаая” төслийн хүрээнд нийт 2000 гаруй хүүхэд хамрагдсан юм.





5

## ТАЙЛАГНАЛ

## ТАЙЛАГНАЛ • Санхүү байдлын тайлан

ҮЗҮҮЛЭЛТ		Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2019	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2018
<b>Хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	сая.төг	260,112.7	261,659.8
Биет бус хөрөнгө ба гүүдвил	сая.төг	92,149.0	96,884.8
Хойшлогдсон татварын хөрөнгө	сая.төг	605.0	1,289.8
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	сая.төг	<b>352,866.8</b>	<b>359,834.4</b>
Бараа материал	сая.төг	89,521.5	76,790.1
Урьдчилгаа, урьдчилж төлсөн зардал	сая.төг	9,352.7	10,911.3
Орлогын албан татварын авлага	сая.төг	3,908.6	100.3
Дансны болон бусад авлага	сая.төг	39,822.8	34,988.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	сая.төг	50,034.9	61,123.9
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	сая.төг	<b>192,640.6</b>	<b>183,913.7</b>
<b>Нийт хөрөнгө</b>	сая.төг	<b>545,507.4</b>	<b>543,748.1</b>
<b>Эздийн өмч</b>			
Хувьцаат капитал	сая.төг	106.3	106.3
Нэмж төлөгдсөн капитал	сая.төг	338,094.9	338,094.9
Нэгдлийн нөөц	сая.төг	(112,795.8)	(112,795.8)
Дахин үнэлгээний нөөц	сая.төг	101,458.1	102,499.3
Гадаад валютын хөрвүүлгийн нөөц	сая.төг	8.2	(6.6)
Хуримтлагдсан ашиг	сая.төг	154,411.1	124,765.6
Хяналтын эрхгүй хувь оролцоо	сая.төг	-	1,731.0
<b>Нийт эздийн өмч</b>	сая.төг	<b>481,282.8</b>	<b>454,394.7</b>
<b>Өр төлбөр</b>			
Хойшлогдсон татварын өглөг	сая.төг	19,383.8	22,954.6
Урт хугацаат түрээсийн өглөг	сая.төг	8,421.6	-
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		<b>27,805.3</b>	<b>22,954.6</b>
Богино хугацаат түрээсийн өглөг	сая.төг	1,700.6	-
Орлогын албан татварын өглөг	сая.төг	1,318.5	3,900.4
Дансны болон бусад өглөг	сая.төг	33,400.1	62,498.3
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	сая.төг	<b>36,419.2</b>	<b>66,398.7</b>
<b>Нийт өр төлбөр</b>	сая.төг	<b>64,224.6</b>	<b>89,353.3</b>
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	сая.төг	<b>545,507.4</b>	<b>543,748.1</b>

## ТАЙЛАГНАЛ • Дэлгэрэнгүй орлогын тайлан

		Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2019	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2018
Борлуулалтын орлого	сая.төг	472,634.2	425,908.2
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	(260,200.1)	(247,281.8)
Нийт ашиг	сая.төг	212,434.2	178,626.5
Борлуулалт, удирдлагын зардал	сая.төг	(112,451.8)	(107,840.4)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	сая.төг	(410.3)	(604.7)
Бусад орлого	сая.төг	3,128.4	3,584.1
Бусад зардал	сая.төг	(3,305.5)	(4,528.2)
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	99,395.0	69,237.2
Санхүүгийн орлого	сая.төг	1,728.3	1,822.2
Санхүүгийн зардал	сая.төг	(2,575.5)	(5,091.9)
Татварын өмнөх ашиг	сая.төг	98,547.8	65,967.5
Орлогын албан татварын зардал	сая.төг	(22,434.9)	(17,724.9)
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	76,112.9	48,242.6
Бусад дэлгэрэнгүй орлого:			
Ашиг, алдагдал руу дахин ангилагдахгүй зүйлс:			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	сая.төг	-	23,941.4
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	сая.төг	35.3	(11.2)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	сая.төг	76,148.2	72,172.7
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох	сая.төг	76,062.5	48,153.3
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	сая.төг	50.4	89.3
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	76,112.9	48,242.6
Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох	сая.төг	76,097.8	72,083.5
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	сая.төг	50.4	89.3
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлогын нийт дүн	сая.төг	76,148.2	72,172.7
Нэгж хувьцаанд ногдох ашиг			
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	сая.төг	71.6	45.3

## ТАЙЛАГНАЛ • Өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ		Хувцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Нэгдлийн нөөц	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт
2018 оны эхний үлдэгдэл	сая.төг	106.3	338,094.9	(112,795.8)	78,756.4	4.6	87,043.6	391,209.9	1,642.6	<b>392,852.5</b>
Нийт дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	-	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	-	-	-	-	-	48,153.3	48,153.3	89.3	<b>48,242.6</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	-	23,941.4	(11.2)	-	23,930.2	-	<b>23,930.2</b>
Зарласан ногдол ашиг	сая.төг	-	-	-	-	-	(10,629.7)	(10,629.7)	(0.8)	<b>(10,630.6)</b>
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн	сая.төг	-	-	-	(198.5)	-	198.5	-	-	-
2018 оны эцсийн үлдэгдэл	сая.төг	106.3	338,094.9	(112,795.8)	102,499.3	(6.6)	124,765.6	452,663.7	1,731.0	<b>454,394.7</b>
Нийт дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	-	-	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	-	-	-	-	-	76,062.5	76,062.5	50.4	<b>76,112.9</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	сая.төг	-	-	-	-	35.3	-	35.3	-	<b>35.3</b>
Зарласан ногдол ашиг	сая.төг	-	-	-	-	-	(48,898.8)	(48,898.8)	-	<b>(48,898.8)</b>
Худалдаж авсан хяналтын эрхгүй хувьцаа	сая.төг	-	-	-	-	-	1,420.1	1,420.1	(1,781.5)	<b>(361.3)</b>
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн	сая.төг	-	-	-	(1,041.2)	(20.4)	1,061.6	-	-	-
2019 оны эцсийн үлдэгдэл	сая.төг	106.3	338,094.9	(112,795.8)	101,458.1	8.2	154,411.1	481,282.8	-	<b>481,282.8</b>

ТАЙЛАГНАЛ • Мөнгөн гүйлгээний тайлан

ҮЗҮҮЛЭЛТ		Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2019	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2018
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн ашиг	сая.төг	76,112.9	48,242.6
Тохируулга:			
Орлогын албан татварын зардал	сая.төг	22,434.9	17,724.9
Зээлийн хүүгийн зардал		-	3,179.8
Түрээсийн хүүгийн зардал	сая.төг	2,203.9	-
Хүүгийн орлого	сая.төг	(1,728.3)	(1,822.2)
Валютын ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй гарз/(олз), цэвэр	сая.төг	(188.7)	(228.4)
Элэгдлийн зардал	сая.төг	32,134.4	34,248.3
Хорогдуулгын зардал	сая.төг	6,866.6	6,874.4
Дансны болон бусад авлагын үнэ цэнийн бууралт, цэвэр	сая.төг	170.3	604.7
Банкны үлдэгдэл дэх үнэ цэнийн бууралт		240.0	-
Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	сая.төг	-	1,952.7
Бараа материалын үнэ цэнийн бууралт (буцаалт)		600.1	529.5
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	сая.төг	(197.3)	(0.5)
Хасагдсан үндсэн хөрөнгө	сая.төг	255.9	48.8
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	сая.төг	502.9	281.1
Биет бус хөрөнгө борлуулсны гарз	сая.төг	4.9	-
	сая.төг	139,412.4	111,635.5
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт:			
Дансны авлага болон бусад авлага	сая.төг	(5,122.3)	8,341.7
Бараа материал	сая.төг	(14,408.3)	(6,580.9)
Урьдчилгаа	сая.төг	1,477.6	(4,508.0)
Дансны өглөг болон бусад өглөг	сая.төг	(559.2)	(1,947.3)
	сая.төг	120,800.2	106,941.0
Зээлийн хүүний төлбөрт төлсөн	сая.төг	-	(3,167.6)
Түрээсийн хүүний төлбөрт төлсөн	сая.төг	(2,203.9)	-
Хүлээн авсан хүүгийн орлого	сая.төг	1,728.3	1,822.2
Төлсөн орлогын албан татвар	сая.төг	(31,688.7)	(13,468.1)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	88,635.9	92,127.4

ҮЗҮҮЛЭЛТ		Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2019	Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан 2018
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	сая.төг		
Худалдаж авсан үндсэн хөрөнгө	сая.төг	(22,227.0)	(12,600.2)
Худалдаж авсан биет бус хөрөнгө	сая.төг	-	(54.5)
Худалдаж авсан хяналтын эрхгүй хувь оролцоо	сая.төг	(57.7)	-
Борлуулсан үндсэн хөрөнгө	сая.төг	1,004.5	679.0
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(21,280.1)	(11,975.8)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Зээлийн эргэн төлөлт	сая.төг	-	(69,077.5)
Төлсөн ногдол ашиг	сая.төг	(77,121.3)	(1,101.7)
Түрээсийн өглөгт төлсөн	сая.төг	(1,241.8)	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(78,363.1)	(70,179.2)
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	сая.төг	23.9	2.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт / (бууралт)	сая.төг	(10,983.4)	9,974.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	сая.төг	61,123.9	51,009.0
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралт	сая.төг	(240.0)	-
Мөнгөн хөрөнгө дэх гадаад валютын ханшийн хэлбэлзлийн нөлөөлөл	сая.төг	134.4	140.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	сая.төг	50,034.9	61,123.9

## ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

### ТАЙЛАГНАЛЫН НИЙЦЭЛ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг Монгол улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актын хүрээнд бэлтгэсэн.

Уг тайланг Санхүүгийн тайлангийн Олон Улсын Стандарт ("СТОУС") 10 буюу "Нэгтгэсэн санхүүгийн Тайлан" хэмээх стандартын арга аргачлалыг ашиглан бэлтгэсэн.

### ҮНЭЛГЭЭНИЙ СУУРЬ

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулахдаа санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

### БҮРТГЭЛИЙН БОЛОН ТОЛИЛУУЛГЫН ВАЛЮТ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг компанийн бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагаа явуулж буй анхдагч эдийн засгийн орчны үндсэн валют болно.

### ТААМАГЛАЛ, ТООЦООЛОЛ БОЛОН ҮНЭЛЭМЖИЙН ХЭРЭГЛЭЭ

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС болон НББОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээр үр дүн нь эдгээр тооцоолоос зөрүүтэй байж болно. Удирдлага эдгээр тооцоолол болон түүнд хэрэглэсэн таамаглалыг байнга хянаж байдаг.

### ГАДААД ВАЛЮТААРХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн зүйлсийг балансын өдрийн хаалтын ханшаар төгрөг рүү хөрвүүлэн илэрхийлдэг.

Бодит үнэ цэнээр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийн зүйлсийг тухайн бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлдэг. Түүхэн өртгөөр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар тайлагнадаг.

### САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ. Компани нь зээл болон авлагыг анх үүссэн тухай бүр нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн хөрөнгүүдийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

АВЛАГА. Уг хөрөнгийг бодит үнэ цэнэ дээр тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан шууд зардлыг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрдөг.

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР. Компани нь гаргасан өрийн бичиг, өр төлбөрийг тухайн ажил гүйлгээг үүссэн өдрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн өр төлбөрийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

### САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙГ ЦЭВЭР ДҮНГЭЭР ТУСГАХ.

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

### ҮНДСЭН ХӨРӨНГӨ

#### АНХДАГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлсийг анхны удаа өртгөөр нь хэмждэг. Өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбогдон гарсан зардлууд багтдаг.

#### ДАРАА ҮЕИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа үндсэн хөрөнгийг түүний бодит үнэ цэнийг илтгэх дахин үнэлсэн дүнгээр хэмжих ба дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байдаг. Хөрөнгийн бодит үнэ цэнийг Монгол Улсын хараат бус гуравдагч этгээд тогтоодог.

#### ДАРАА ҮЕИЙН ЗАРДАЛ.

Дараа үеийн зардлыг зөвхөн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай гэдэг нь тогтоогдсон үед капиталжуулан бүртгэдэг. Урсгал засварын зардлыг гарсан тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

#### ЭЛЭГДЭЛ.

Үндсэн хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар элэгдүүлж, орлогын тайланд бүртгэдэг. Үндсэн хөрөнгийг түүнийг байршуулж, ашиглахад бэлэн болсон үеэс нь, дотооддоо барьж байгуулсан хөрөнгийн хувьд тэдгээрийг дуусгавар болгож, үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон үеэс нь эхлэн элэгдэл байгуулдаг.

#### БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Компани биет бус хөрөнгө худалдан авсан бөгөөд түүний ашиглалтын жилийг тодорхойлох боломжтой бол түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

### БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

Биологийн хөрөнгийг борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд үүнтэй холбоотой үүсэх олз ба гарзыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

### ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

Компани бэлтгэл шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн хэсэг болгон капиталжуулдаг. Бусад зээлийн өртгийг гарсан тайлант үед нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.

### БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлдэг. Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардлууд ордог. Үйлдвэрийн бараа материал, дуусаагүй үйлдвэрлэлийн хувьд хэвийн хүчин чадлаар ажиллах үеийн үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын зохих хэсгийг өртөгт хуваарилдаг.

### ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

#### ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хөрөнгийн хувьд тэдгээрт үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог.

#### ХОРОГДУУЛСАН ӨРТГӨӨР ИЛЭРХИЙЛСЭН САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Компани эдгээр хөрөнгүүдийг тусад нь мөн хамтад нь үнэ цэнийн бууралтын нотолгоо байгаа эсэхийг үздэг. Бүх мэдэгдэхүйц хэмжээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тусад нь үнэлнэ.

#### САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ.

Тайлант үеийн эцэст бараа материал, хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад санхүүгийн бус хөрөнгийн дансны үнэнд үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно.

### АЖИЛЧДЫН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, УРАМШУУЛАЛ

АЖИЛЧДЫН БОГИНО ХУГАЦААТ ТЭТГЭМЖ. Холбогдох үйлчилгээ үзүүлсэн үед ажилчдын богино хугацаат тэтгэмжийг зардлаар бүртгэдэг. Компани нь ажилтны үзүүлсэн үйлчилгээний дагуу компанид үүрэг хариуцлага үүссэнээс найдвартайгаар тооцоолж болох компанийн төлөх ёстой дүнгээр өр төлбөрөө хүлээн зөвшөөрдөг.

## ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

ТОГТООСОН ШИМТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ. Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн Даатгалын Санд төвлөрүүлэх хуулиар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ. Тодорхой шимтгэлийн дүн бүхий тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөрт төвлөрүүлэх шимтгэлийг түүнийг төлөх үүрэг хүлээсэн тайлант үеийн зардлаар бүртгэдэг.

### НӨӨЦ БА БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Компани өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед санхүүгийн байдлын тайланд нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

### ХУВЬЦААТ КАПИТАЛ ЭНГИЙН ХУВЬЦАА

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж, бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

### ХАЛААСНЫ ХУВЬЦАА

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татварын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бууралт гэж бүртгэдэг.

Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд халаасны хувьцаа гэж тайлагнадаг. Халаасны хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэнд гаргасан үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөөд тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

### ХУВЬЦААТ КАПИТАЛ, НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ БА БУСАД НӨӨЦҮҮД

Эвэргрийн Инвестментс ХХК-тай нэгдсэн талаар Холбогдох эрх бүхий байгууллагуудаас зохих зөвшөөрлүүдийг шат дараатай авсны үндсэн дээр нэгдлийн ажил гүйлгээ 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөр дуусгавар болсон. Эцсийн үе шатанд Эвэргрийн Инвестментс ХХК компанид нэгдсэн бөгөөд компани нь нэгдсэн компаниуд, тэдгээрийн охин компаниудын толгой компани болсон.

Нэгдлийн үр дүнд дараах өмчийн дахин зохион байгуулалтыг хийсэн:

2017 оны 8 дугаар сарын 18-ны өдөр компанийн хувьцаа эзэмшигчид нийт 338,127,000 мянган төгрөгөөр капиталыг нэмэгдүүлэх замаар Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд нийт 321,305 мянган ширхэг энгийн хувьцааг шинээр гаргасан. Уг капитал нь 32,130 мянган төгрөгийн хувьцаат капитал болон 338,094,870 мянган төгрөгийн нэмж төлөгдсөн капиталас бүрдсэн.

### Нэгдлийн нөөц

Бизнесийн нэгдлийн хүрээнд компанийн шилжүүлсэн төлбөр нь Эвэргрийн Инвестментс ХХК-тай хийсэн нэгдэлд зориулж шинээр гаргасан хувьцаа болно. Өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо бодит үнэ цэнийн 1 дүгээр шатлалын хэмжүүр болох компанийн хувьцааны зах зээлийн үнэ цэнийг ашигласан. Нэмж гаргасан хувьцааны бодит үнэ цэнэ болон хуулийн дагуу бүртгэгдсэн үнэ цэнийн зөрүү болох 112,795,804 мянган төгрөгийг нэгдлийн нөөц гэж бүртгэсэн.

### ОРЛОГО

Бараа борлуулалтын орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэлд тусгадаг. Ингэхдээ компани эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлал өндөр бөгөөд орлого ба өртөг зардлыг бодитоор хэмжих боломжтой байх ёстой.

### БАРАА БОРЛУУЛАЛТ

Бараа агуулахаас ачигдан, худалдан авагчийн талбайд хүргэгдэж, худалдан авагч бараа хүлээн авч, эрсдэл болон өмчлөл нь худалдан авагчид бүрэн шилжсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрдөг. Орлогын дүнд нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад борлуулалтын татварыг оруулдаггүй ба худалдааны хөнгөлөлт, урамшууллыг хассан цэвэр дүн байдаг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮРЭЭСИЙН ОРЛОГО. Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид төлөгдөх ижил хэмжээний хэсэгчилсэн төлөлтөөр орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн хөрөнгийн урамшууллыг түрээсийн нийт зардлын дүнд тооцон түрээсийн хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Болзошгүй түрээсийн орлогыг тухайн орлогыг олсон тайлант хугацаанд хүлээн зөвшөөрдөг.

### БУСАД ОРЛОГО

Компанийн үндсэн үйл ажиллагаанаас гадна бий болж буй орлогыг бусад орлого гэх бөгөөд тухайн орлогын эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай ба үүнийг найдвартай хэмжин тодорхойлох боломжтой болсон үед компани бусад орлогыг хүлээн зөвшөөрдөг.

### САНХҮҮГИЙН ОРЛОГО БА САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтаас хүртэх хүүгийн орлого орно. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд хуримтлуулан бүртгэдэг.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрддэг. Зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд бүртгэдэг.

### ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Тайлант жилийн татвар болон хойшлогдсон татварыг эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоор шууд хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

### НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ

Компани энгийн хувьцааны хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог.

### ХОЛБООТОЙ ТАЛУУД

Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг;
- Компанид мэдэгдэхүйц нөлөөлөлтэй;
- Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь компанитай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж болзошгүй гэр бүлийн гишүүд юм.

## ТАЙЛБАР ТОЛЬ

### ТАЙЛАНТ ҮЕ

Аж ахуйн нэгж, байгууллагын ашиг, алдагдлыг тооцож буй хугацааг хэлнэ. Ерөнхийдөө улирал, жилийг хамруулж авч үзнэ.

### САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Иж бүрэн санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдэнэ.

### ХӨРӨНГӨ

Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болж, байгууллагын мэдэлд орсон бөгөөд ирээдүйд үр өгөөжөө өгөх нөөц, баялаг, хөрөнгө юм.

### ББХ-БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгөтэй адил биетээр, бодитоор оршдоггүй хэдий ч эзэмшигчдэдээ давуу тал болон давуу эрхийг олгодог патент, лиценз, зохиогчийн эрх, барааны тэмдэг, нэр төр, гүүдвил гэх мэт удаан хугацаанд үнэ цэнэтэй байх актив (хөрөнгө)-ыг хэлнэ.

### ҮХ-ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Байшин, барилга, машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил гэх мэт худалдан борлуулах зориулалтгүй, үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаанд урт хугацаанд ашиглагдах буюу 1 жилээс бага хугацаанд борлогдож мөнгөн хөрөнгө болохгүй хөрөнгийг хэлнэ.

### ЭБХ-ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийг хэлнэ.

### ЭХ-ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад ашиглагдах нэг жил буюу түүнээс бага хугацаанд бэлэн мөнгө болж хувирах хөрөнгийг хэлнэ.

### УТЗ-УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ

Ажил үйлчилгээ авахаас өмнө буюу үр дүн нь гарахаас өмнө төлсөн төлбөр

### ДАНСНЫ АВЛАГА

Үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах мөнгөн дүн.

### БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат хөрөнгө оруулалт хамаарна.

### МӨНГӨТЭЙ ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ

Үнэ цэнийг нь өөрчлөхөд өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөнд шууд хөрвөх нэгээс гурван сарын хугацаатай хөрөнгө оруулалт юм.

### МӨНГӨН СУУРЬТ АРГА

Бэлнээр мөнгө хүлээж авсан үед нь орлогод, бэлнээр мөнгө төлсөн үед нь зардалд бүртгэх нягтлан бодох бүртгэлийн арга.

### АККРУЭЛ СУУРЬТ АРГА

Мөнгө хүлээн авсан, эсхүл төлснөөс үл хамааран ажил үйлчилгээний гүйцэтгэлтэй уялдуулан орлогыг олсон, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

### ХУВЬЦААТ КАПИТАЛ

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө юм.

### ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ

Аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн дүнг хэлнэ.

### ӨР ТӨЛБӨР

Бусдад төлөх ёстой мөнгө (хувь хүн, компани, эсхүл Засгийн газрын өр байж болно).

### УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийг хэлнэ.

### БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг хэлнэ.

### НДШ-НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг санхүүжүүлэх зорилгоор ажилчид болон ажил олгогчдод ногдуулах татвар.

### ОТ-ОРЛОГЫН ТАЙЛАН

Компанийн олсон орлого, гаргасан зардлыг тодорхой хугацаагаар (улирал, жил) тасалбар болгон харуулсан тайлан

### БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Тайлангийн хугацаанд худалдсан бараа, бүтээгдэхүүн үйлчилгээний үйл ажиллагаанаас олсон орлогыг хэлнэ.

### БОРЛУУЛАЛТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

Тайлант үед борлуулсан барааны өртгийг хэлнэ.

### НИЙТ АШИГ

Байгууллагын тодорхой хугацаан дахь үйл ажиллагааны үр дүнгийн мөнгөн илэрхийлэл буюу бизнес эрхэлж, эрсдэл хүлээсний төлөө авч буй үр өгөөж, компанийн нийт орлогоос бүх мөнгөн болон хийсвэр зардлыг хасч тооцно.

### ҮАЗ-ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ ЗАРДАЛ

Бизнес эрхлэхэд гарч буй зардал.

### ХТӨА

Хүү татварын өмнөх ашиг

### ЦЭВЭР АШИГ

Компанийн орлогоос бүх төрлийн зардал болон татварыг хасаад үлдэж буй ашгийн хэмжээ.

### ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

Орлогын албан татварын зардал нь орлогын албан татварын өмнөх ашиг нь хувиар илэрхийлсэн

### ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Засгийн газраас аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогод ногдуулж буй татвар

### МГТ-МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг харуулсан тайлан

### ҮҮАМГ

Үндсэн Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ байгууллагын орлого олох үндсэн үйл ажиллагаанаас орж ирэх мөнгөн хөрөнгийг хэлнэ

### ГХО

Гадаадын хөрөнгө оруулалт